

Ногоон хөгжлийн төлөө

MONGOLIAN ECONOMY

Монголын эдийн засаг, бизнесийн сэтгүүл

2014 он. 2 сар. №03 (061)

www.mongolianeconomy.mn


Сочигийн өвлийн олимпын төсөв

Жишиг үнээс эрдэс
баялгийн бирж рүү

Чи агис боод

Самурай боод

ЭРСДЭЛ ДАЛЛАХ
ИХ МӨНГӨ



Шог зургийг А.Амарсайхан



Bose® Solo TV sound system

Таны телевизорын дуугаралтыг
төгс болгох хялбар шийдэл

Үнэ: 880.800 төгрөг

Сүхбаатар дүүрэг, Хүнсний 4-р дэлгүүрийн хойд талд, PC mall
Саммит Компьютер Технологи ХХК, Улаанбаатар-14193, Монгол улс

 7011-3535

 Visit us:
www.pc-mall.mn

 Join us on Facebook
<http://www.facebook.com/PCmallOfficial>

BOSE
Better sound through research®

Сар шинийн мэнд дэвшурье...

Мэдээллийн нэгдсэн сан гэж юу вэ?

- * Logo3s.mn
- * Reclam6s.mn
- * Mobile web
- * Application Reclam6s /App store, Playstore/
- * Реклам мэдээллийн сан
- * Media сурталчилгаа




Эрж хайсан зүйлээ
RECLAM6S
application - аас

TOUCHSCREEN TV
Медиа
сурталчилгаа

- 1.ВИДЕО РЕКЛАМ
- 2.ФОТО ТАНИЛЦУУЛГА
- 3.ТЕХТ ЗАР /УРСДАГ/

LOGO3S.MN

RECLAM6S.MN
MOBILE WEB



Харилцах утас:
7010-0156, 9111-6586

For a green development

MONGOLIAN ECONOMY

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ЭРХЛЭГЧ:

Д.Бэхбаяр / 9999-4248

ҮҮСГЭН БАЙГУУЛАГЧ, ОРЛОГЧ ЭРХЛЭГЧ:

И.Отгонжаргал / 8800-6228

ЕРӨНХИЙ РЕДАКТОР:

Б.Цогзаяабаатар / 9919-0715

АНГЛИ ХЭЛНИЙ РЕДАКТОР:

Теренс Эдвардс

ОРЧУУЛАГЧ:

Р.Гантулга

СЭТГҮҮЛЧИД:

Б.Баяртогтох

Э.Зоригт

Х.Хулан

Б.Үүрийнтуяа

Б.Бямбадорж

ДИЗАЙНЕР:

Ш.Оюундарь

ВЭБ МАСТЕР:

Н.Гал

МАРКЕТИНГИЙН МЕНЕЖЕР:

Д.Бариянжав / 9409-2904

Д.Баттулга / 9409-2905

БОРЛУУЛАЛТЫН МЕНЕЖЕР:

М.Хишигтогтох / 9409-2906

“ECONOMY” ТВ СТУДИ

СЭТГҮҮЛЧ:

Ц.Соёлмаа

ЗУРАГЛААЧ:

Ш.Гантуул

КОМПЬЮТЕР ГРАФИКЧ:

Т.Баярсайхан

ХАЯГ:

Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг. VI
хороо, Их сургуулийн гудамж.

AV center. 503 тоот

15160 Улаанбаатар,

Төв шуудан, ш/ х-2762

www.mongolianeconomy.mn

info@mongolianeconomy.mn

Утас/Факс: 976 - 7011 5476

“Улаанбаатар принт” ХХК-д хэвлэв

www.ubprint.mn



РЕДАКЦИД
ЗАХИАЛБАЛ
ХҮРГЭЛТ
ҮНЭГҮЙ

MONGOLIAN ECONOMY ОНЛАЙН СЭТГҮҮЛИЙГ

<http://mongolianeconomy.imedia.mn/>

АГУУЛГА

БИЗНЕС

- 8 “Чингис” бонд юу өгөв
- 10 Чингис бондын зарцуулалтын эдийн засгийн үр нөлөөг үнэлэх нь
- 13 Монгол бэлэг
- 15 Бидний өмнө гурван тэрбумын зах зээл байна
- 18 Овоо хараанд “катерпиллар”
- 19 Үнэгүйдэл үргэлжилсээр
- 20 Калькуттын төмөр эр

ЭДИЙН ЗАСАГ

- 22 Гарцаа зөв тодорхойл
- 24 Б.Дэлгэрмаа: Сингапурын сайн туршлагаудыг нэвтрүүлмээр байна
- 28 Сочигийн өвлийн олимпын төсөв
- 30 Эдийн засаг дахь төрийн оролцоог багасгана
- 31 Уул уурхай хийгээд хөрөнгийн төлөөх голбал өрсөлдөөн
- 33 Жишиг үнээс эрдэс баялгийн бирж рүү
- 34 XXI зууныг бүтээсэн нь
- 37 Эдийн засгийн субъектүүд ба зах

“ECONOMY” ТВ СТУДИ



“МӨНГӨӨР ӨРГӨЖИХ ЦАГААН САР” нэвтрүүлэг

Нэвтрүүлэх суваг: NTV телевиз

Нэвтрүүлэх цаг: 2014.02.04-ний 21.50 цаг

Монголчууд жилээс жилд сар шинийн баяраар бэл бэнчингээр өрсөлдөж, мөнгөөр өргөжүүлэх боллоо. Үүний цаана баярын гол утга болох түүх соёл, өв уламжлал мартагдаж байна.

2013 оны Шилдэг сэтгүүрт

“MONGOLIAN ECONOMY” СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Б.БССМБАСАЙХАН Монголын бизнесийн зөвлөлийн ТУЗ-ийн дарга, “Mongolian Economy” сэтгүүлийн Зөвлөлийн тэргүүн

Б.БОЛД “Рио Тинто” компанийн Зэсийн группын Олон улсын үйл ажиллагаа эрхэлсэн Ерөнхийлөгч

С.БЭХБАТ ЭЗХЯ-ны Инноваци, төр, хувийн хэвшлийн түншлэлийн газрын дарга

Д.ЖАРГАЛСАЙХАН МIН группын ерөнхийлөгч

Ц.БАТСҮҮХ СЭЗДС-ийн Эдийн засгийн тэнхимийн эрхлэгч

Ж.СҮНЖИДМАА “Пийбоди Энержи” компанийн Монгол дахь хамтын ажиллагаа, олон нийтийн асуудал хариуцсан менежер

Б.ТҮВШИНТӨГС Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн захирал

ХОЛБООС



facebook.com/Mongolian.Economy



twitter.com/EconomyMongolia



youtube.com/user/MongolianEconomy

Борлуулах цэгүүд:

- “Интер ном”
- “Цэцэг төв”
- “Минж плаза”
- “Алтантүлхүүр” номын дэлгүүр
- “Номин” супермаркетийн бүх салбар
- “Макс” супермаркетийн бүх салбар
- “Фреско” супермаркет
- BTSI супермаркет
- “Аз орчлон” номын дэлгүүр
- “Билэг” их дэлгүүрийн номын тасаг
- “Гранд Плаза” дахь супермаркет
- “Мир” номын дэлгүүрийн
- “Grand plaza”
- “Metro mall”
- “Sky” супермаркет
- “Улаанбаатар” их дэлгүүр дэх салбар
- “Max mall” салбарууд

МОНГОЛ



Оюутолгой

“Оюу Толгой” ХХК-ийн ТУЗ-ийн мэдээлж байгаагаар далд уурхайн санхүүжилтийн асуудал морин жил гарахын өмнө шийдэгдэж магадгүй. Усны хэрэглээ ба хураамж, роялти, хоёр тэрбум ам.долларын зардлын хэтрэлт, далд уурхайн ТЭЗҮ-г батлах зэрэг асуудал шийдэгдээгүй байна. ТУЗ-өөс Оюу толгойн энэ оны төсвийг баталсан. Энэ нь 1.28 тэрбум ам.доллар ба төслийн орлого 2014 онд 2.65 тэрбум ам.доллар байна гэж тооцоолжээ. Далд уурхайн нийт хөрөнгө оруулалтын хэмжээ ойролцоогоор 6.6 тэрбум ам.доллар байна.

Төмрийн хүдэр

“Naranga Resources” компани 80 хувийг нь эзэмшиж буй Сэлэнгийн төмрийн хүдрийн төслийг хэрэгжүүлэхээр Монголын ашигт малтмалын хэрэг эрхлэх газартай гэрээ байгуулжээ. Төслийн байршил нь Дархан-Сэлэнгийн төмрийн ордуудын бүсэд харъяалагдаж байгаа. Мөн төмөр замтай ойр байршдаг. Гэрээний гол нөхцөл нь Naranga Resources компани уг төслийн ТЭЗҮ-ийг дуусган, батлах юм. Сэлэнгэ төсөл нь Жоркийн тайлангаар 254 сая тн нөөцтэй, төмрийн агууламж нь 17.2 хувь. Судалгаанаас харахад төмрийн агууламжийн хувь 66 хувьд ч хүрэх боломжтой байгаа аж.

Төмөр зам

Төмөр замын бүтээн байгуулалтын ажлын техникийн зөвлөх “Nippon Koei” компани Тавантолгойгоос Сайншанд чиглэлд тавигдах төмөр замын зураг төслийг “Монголын төмөр зам” компанид хүлээлгэн өгсөн байна. Зураг төсөлд ажил гүйцэтгэгчийн баримтлах техникийн стандарт, шаардлага тендерийн баримт бичиг зэрэг бичиг багтжээ. Зураг төслийг боловсруулахдаа газар зүйн онцлог, газар шорооны нөхцөл гээд олон үзүүлэлтийг харгалзан төмөр зам барих стандарт, техникийн шийдлийг 20, 20 метрээр нарийвчлан гаргасан байна. Одоогоортөмөр замын техникийн зураг төсөл боловсруулалт, судалгааны ажил төлөвлөгөөний дагуу 78 хувийн гүйцэтгэлтэй байгаа талаар “Nippon Koei” компаниас мэдээллээ.



Банк

Мүүдсийн үнэлгээгээр Хаан, ХХБ, Хас банкуудын үнэлгээг “тогтвортой”-гоос “сөрөг”-рүү орсон байна. Чанаргүй зээлийн өсөлт, эдийн засгийн өсөлтийн удаашрал, үйл ажиллагааны орчин муудаж байгаа зэрэг нь “сөрөг” үнэлгээ авахад голчлон нөлөөлжээ. Мөн экспортын 90 хувь нь түүхий эдэд чиглэсэн төдийгүй уул уурхайд төвлөрсөн байгаа. Энэ нь түүхий эдийн үнийн уналтын үед эдийн засгийг тогтворгүй болгож

байгаа аж. Зээлийн хэмжээ өнгөрсөн оны нэгдүгээр сараас арван нэгдүгээр сар хүртэл 55 хувь өсч нь өмнөх жилийн мөн үеийн үзүүлэлтээс 23 хувиар өссөн байгаа юм.


Санхүүгийн зах зээл

Санхүүгийн зохицуулах хороо, Японы Санхүүгийн үйлчилгээний агентлаг /FSA/-тай хамтран ажиллахаар боллоо. Ингэснээр хөрөнгийн зах зээлийн зохицуулалтын

тогтолцоог сайжруулах. Мөн санхүүгийн зах зээлийг хөгжүүлэх хэтийн зорилтын хүрээнд мэдлэг, туршлага солилцооны хөтөлбөрийг хэрэгжүүлэх чиглэлээр хоёр тал хамтран ажиллах юм. Санхүүгийн захын хөгжлийг дэмжих зорилго тээсэн дээрх хоёр зохицуулагч байгууллагын хувьд хамтын ажиллагаагаа улам бэхжүүлэх үүднээс санамж бичигт гарын үсэг зурсан байна.

Хөдөлмөрийн зах зээл

Үндэсний статистикийн хорооны гаргасан судалгааны дүнгээс харахад барилгын салбарт ажлын байр хамгийн их эрэлттэй байв. Нийт ажлын байрны 28 хувийг дангаараа бүрдүүлж байна. Мөн үйлдвэрлэл, худалдаа, борлуулалтын салбар нь 20 хувь, банк санхүү, эрүүл мэнд, уул уурхай тус тус 10 хувийг эзэлж байна. Боловсрол, даатгал, программ хангамж, эрчим хүч, хууль, хөдөө аж ахуй салбаруудад таван хувиас доош ажлын байруудыг санал болгожээ.



Эх сурвалж: Хөдөлмөрийн бирж

Бизнесийн орчны судалгаа (2013)



Эх сурвалж: Дэлхийн банк

ДЭЛХИЙ ДАХИНД:




АНУ

Эдийн засгийн эрх чөлөөний индексээр АНУ өнгөрсөн онд арванхоёрдугаарт оржээ. Тус улс энэ үзүүлэлтээр сүүлийн долоон жилд тасралтгүй доошилж буй. Энэ нь өмчийн эрх болон авлигаас ангид байх эрх чөлөөнд гарсан томоохон сөрөг өөрчлөлт. Мөн Засгийн газрынх нь зардал нэмэгдсэнтэй холбоотой гэж уг судалгаанд дурджээ.

БНХАУ

Урд хөршийн эдийн засгийн



өсөлт өнгөрсөн онд сүүлийн 14 жилд байгаагүйгээр удаашрав. ДНБ нь өнгөрсөн оны сүүлийн улиралд 7.7 хувиар өсчээ. Энэ нь Засгийн газрынх нь 7.5 хувь байх болов уу гэсэн таамгаас ялимгүй дээгүүр үзүүлэлт аж. Тус улсын бодлого тодорхойлогчид эдийн засгаа сайжруулах үүднээс өсөлтийг цаашид хадгалах хүндхэн сорилттой тулгараад буй. Тус улс хөрөнгө оруулалтад суурилсан загвараас дотоодын хэрэглээнд суурилсан загварт шилжихийг зорьж байгаа аж.

Япон

Японы Засгийн газар эдийн засгийн ерөнхий үнэлгээгээ

дээшлүүлж тооцсон байна. Дэлхийн санхүүгийн хямрал 2008 онд АНУ-д нүүрлэснээс хойш анх удаа эдийн засгаа “сэргэж буй” хэмээн тодорхойлсон нь энэ аж. Үүнийг хэрэглээний зардлыг нэмэгдүүлэхэд ихээхэн анхаарсан. Үр дүнд нь бизнесийн хөрөнгө оруулалт сайжирсантай холбоотой гэжээ.

Герман

Германы “Deutsche Bank”



өнгөрсөн оны сүүлийн улиралд ихээхэн алдагдал хүлээжээ. Энэ талаар сүүлд гаргасан тайландаа дурдсан байна. Тус банкныхан 1.153 их наяд еврогийн алдагдалтай байсан талаар мэдэгдэв. Үүнд хууль, шүүх болон бүтцийн өөрчлөлттэй

холбоотой зардлууд ихээхэн нөлөөлсөн гэж үзэж байгаа аж. Хууль, шүүхтэй холбоотой зардал гэхэд л 528 сая евро болж, орлого нь мөн үеэр 16 хувиар буурсан байна.



Их Британи


Их Британийн санхүүгийн үйлчилгээний салбарт эдийн засгийн сэргэлтийн шинж тэмдэг илэрчээ. Өнгөрсөн оны сүүлийн улиралд ашиг, бизнесийн цар хүрээ, өөдрөг байдлаараа бүх компанийн 68 хувь нь өссөн үзүүлэлтэй байв. Үүнийг CBI/PwC компанийн санхүүгийн үйлчилгээний талаар хийсэн судалгаа харуулжээ. Энэ нь 1989 оноос хойш



байгаагүй хамгийн өндөр үзүүлэлт аж.

ОХУ

ОХУ-ын Эрчим хүчний сайд Александр Новак, Европын холбооны Эрчим хүчний комиссар Гунтер Херманн Ойттингер нар өнгөрсөн сард Москвад уулзав. Тэд “Газпром”-ын эсрэг Европын холбооноос үүсгэсэн гомдлын асуудлаар хэлэлцжээ. Энэ нь Оросын компанийн монопол эрхийн талаар юм. Уулзалт төдийлэн үр дүнтэй болоогүй аж. Харин хоёр тал Германы OPAL байгалийн хийн хоолой зэрэг Европын байгалийн хийн дэд бүтцийг ашиглах тухайд илүү сайн ойлголцолд хүрч чадсан байна. ■



ОНЦЛОХ

ЧИНГИС БОНД ЮУ ӨГӨВ?



Б.БАЯРТОГТОХ

Засгийн газар ДНБ-ий тавны нэгтэй тэнцэх хэмжээний бонд босгоод ч ам.долларын ханш дорвитой бууж чадсангүй. Манай улс “Чингис” бондын хүүний төлбөрт жилд 75 сая ам.доллар буюу одоогийн ханшаар 129 тэрбум төгрөг. Өдөрт 208.3 мянган ам.доллар буюу 385 сая төгрөг төлж байна. Ингэснээр гурван жилийн дараа 500 сая ам.долларын өрийг нэг өдрийн дотор төлж барагдуулах юм. Ам.долларын ханш чангарах бүрт бондын эргэн төлөлтөд хүндрэл үүсч буй. Тиймээс маш хурдан хугацаанд үр ашгаа өгөх төсөлд эрсдэлгүйгээр энэ мөнгийг зарцуулах учиртай. Засгийн газраас “Чингис” бондыг өр биш хөрөнгө оруулалтын зээл хэмээн онцолж буй. Зээл өр болж үлдэх нь бий.

Төсвийн тогтвортой байдлын тухай хуулиа Засгийн газар дур мэдэн зөрчөөд энэ онд “Самурай” бонд босгочихлоо. Уг нь Төсвийн тогтвортой

байдлын тухай хуульд Монгол Улсын нийт өр 2014 онд ДНБ-ий 40 хувиас хэтрэхгүй байхаар хуульчилсан. Гэтэл дээрх бондыг гаргаснаар ДНБ-д эзэлж байгаа өрийн хэмжээ 43 хувь болохоор байгаа нь хууль зөрчсөн гэж дүгнэхэд хүргэж байна. Таамаг төдий бондын чимээ эдийн засагт таатай угтал болсонгүй. Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал Н.Мөнхбат “Нийт 30 тэрбум иенийг авахаар болсон. Эхний ээлжинд 24.3 тэрбум иен манай дансанд орсон байгаа. Бондын мөнгийг ХААН, Худалдаа хөгжлийн банкуудад байршуулсан. Японы олон улсын хамтын ажиллагааны банк баталгааны шимтгэл гэж 5.7 тэрбум иенийг суутгаж авсан” хэмээн мэдэгдсэн.

Японы зах зээлд гаргасан “Самурай” бондын үндсэн төлбөрийг 10 жилийн дараа нэг дор буцааж төлөх юм. Бондын жилийн хүү нь 1.52. Манай зүгээс хөрөнгө оруулагчдад жилд дунджаар 4.4 сая ам.долларыг хүүгийн төлбөрт өгөх аж.

“Засгийн газар 2012 оны төгсгөлөөр “Чингис” бонд гаргахаас өмнө манай улсын өрийн түвшин хэвийн хэмжээнд байсан. Харин 2012 оноос хойш эрсдэлтэй орны тоонд багтаж яваа” гэж Дэлхийн банкны Монгол Улс дахь Суурин төлөөлөгчийн газрын эдийн засагч Ш.Алтанцэцэг хэллээ.

Олон улсын санхүүгийн “далай”-гаас 2012 онд босгосон 1.5 тэрбум “Чингис бонд”-ын хөрөнгөөс 360 сая ам.доллар үлдсэн. Үүнийг импортыг орлож, экспортыг нэмэгдүүлэх үйлдвэрлэлд зарцуулахаар Засгийн газар шийдсэн. Энэ оныг баялаг бүтээгчдийг дэмжих жил хэмээн Ерөнхий сайд Н.Алтанхуяг зарласан нь бас учиртай. Одоогоор сүү, мах, ноос ноолуур, оёмол сүлжмэл, хүлэмжийн үйлдвэрлэлийг дэмжихэд “Чингис” бондоос 270 тэрбум төгрөгийг зарцуулаад байна. Мөн төмөр зам болон авто замын бүтээн байгуулалтад бондоос хөрөнгө хуваасан.

Бонд босгосон даруйд бэлэн төсөл байгаагүй нь Шинэчлэлийн Засгийн газрыг буруутгах үндэслэл болсон. Тэгвэл өнөөдөр алдаагаа засах үүднээс үлдэгдэл хөрөнгөө импортыг орлох экспортыг дэмжих төслүүдэд шахах гэж байгаа нь сайн хэрэг боловч эргэлзээ төрүүлсээр.

Төслийн саналыг нэг сар хүрэхгүй хугацаанд хүлээн авсан. Ингэснээр ирэх сарын 15-ны дотор сонгон шалгаруулна. Төсөл хүлээн авах хугацаанд нийт 1154 төсөл ирсэн. Үүнээс 963-ыг Засгийн газрын хэрэг эрхлэх газарт хаяглан дугтуйлжээ. Уг нь эртнээс л ингэх байсныг Монгол Улсын Ерөнхий сайд асан Д.Содном хэлээд “Бонд гаргах нь буруу биш. Харин тэр бондын мөнгийг өөрийнхөө мөнгө мэт өөриймсөг сэтгэлээр төлөвлөж, нарийн сайн тооцоолох хэрэгтэй” хэмээн өгүүлсэн. Гэвч ▶▶

▶ богино хугацаанд шаардлага хангахуйц эдийн засгийн үр ашигтай сайн төслийн санал ирсэн эсэх нь дээрх дүгнэлтийг хийхэд хүргэж байгаа юм.

Ерөнхий сайдын захирамжаар байгуулагдсан Зээлийн судалгаа, экспертизийн ажлын хэсэг дээрх төсөлд шалгаруулалт хийж үзээд боломжтойг нь мөнгөжүүлнэ. Ажлын хэсгийг Хөгжлийн банкны гүйцэтгэх захирал Н.Мөнхбат ахалж байна. Тэдний шүүлт хэр мэргэн, шалгаруулалт хэр тунгалаг байхаас Чингис бондын 360 сая ам.долларын баялаг бүтээх эсэх нь шалтгаалах юм. Үйлдвэржилтэд энэ жил нийтдээ нэг их наяд төгрөгийг зарцуулахаар Засгийн газар төлөвлөж буй. Үүний 360 тэрбум нь “Чингис” бондоос, 270 тэрбумыг хөдөө аж ахуйн салбараас, үлдсэнийг нь “Самурай” бондоос зарцуулах юм.

СЭЗДС-ийн багш Д.Мөнхзаяа “Дэлхий дээр 85 их наяд ам.долларын Засгийн газрын бонд байдаг гэсэн статистик байдаг. Бонд нь өрийн нэг хэлбэр. Тухайн өрийг төлөх хэмжээний үйл ажиллагаа явуулахгүй бол үр ашигтай төсөл, хөтөлбөрүүд санхүүжүүлээгүй тохиолдолд өрийн дарамтад орох. Улмаар дараагийн санхүүгийн хямрал үүсгэх гол шалтгаан болж болзошгүй” гэж “Чингис бондын зэрэг ба сөрөг нөлөө” өгүүлэлдээ бичжээ.

Манай улсын хувьд дэлхийн улсуудын түгээмэл хэрэглээ болоод буй “Бонд”-ын санхүүжилтэд хайр зарлах болсон. Гэхдээ бондын санхүүжилт нь улсын санхүүгийн системийг унагах хэмжээний эрсдэлтэй хэрэгсэл гэдгийг байнга санахад илүүдэхгүй. Цаашид ам.долларын ханшаа тогтворжуулах. Одоогийн байгаа /1720/ түвшингээс бууруулахгүй бол төгрөгийн ханшийн сулрал багагүй ачааллыг төсөвт үүрүүлэх бололтой. Өөрөөр хэлбэл, бид ханшийн зөрүүнээс үүдэн алдагдал хүлээнэ гэсэн үг. “Чингис” бонд гаргах үед ам.долларын ханш 1395 төгрөгтэй тэнцэж байсан. Тэгвэл өнөөдөр ам.долларын ханш 1700 төгрөг хэдийнэ давчихаад байна.

Ам.долларын ханш чангарсан нь бүхэлдээ эдийн засагт дарамт болж, үнийн өсөлтийг дуудсан.

Засгийн газарт задгай бус бүхэл мөнгө хэрэгтэй. Бүхэл мөнгө нь өдгөө бонд болчихоод байгаа нь “Самурай” бондоор үргэлжлэв. Хэрвээ 1.5 тэрбум ам.доллар босгоогүй бол

валютын ханш 1800 төгрөг хүрэхийн сацуу инфляцийн түвшин 25 хувьд хүрэх эрсдэл байгааг жилийн өмнө Ч.Улаан сайд тайлбарлаж байв. Гэтэл ам.долларын ханш өнгөрсөн оны адагт дээрх тоонд ойртлоо.

Сүр бадруулсан “Чингис” бонд өр эсвэл өв үлдээх үү гэдгийг одоогоор хэлэхэд эрт байна. Тус бондын хувьд хагас жил бүр хүүгээ төлөх нөхцөлтэй. Таван жилийн хугацаатай бондын үндсэн төлбөрийг 2017 онд, арван жилийн хугацаатай бондын үндсэн төлбөрийг 2022 онд манай улс хөрөнгө оруулагчдад төлөхөөр байгаа. Тиймээс одооноос өрөө хэрхэн төлөх асуудлаа ний нуугүй ярилцах учиртай.

“Чингис” бонд эдийн засгийн өсөлтийг хангахад хөрөнгө оруулалтын эх үүсвэр болсон. Мөн амьдрал залгуулах мөнгө гэдгийг Сангийн сайд хэлж байв. Нэг талаасаа эдийн засгийн өсөлтийг хоёр оронтой тоонд хадгалж үлдэхэд “Чингис” бонд үүргээ гүйцэтгэсэн. Үүнээс гадна төсвийн хөрөнгө оруулалтаар хийх ажлын 70 гаруй хувийг “Чингис” бондоор нугалсан. Уг нь гудамж тохижуулж, зам тавих гэж 1.5 тэрбум ам.доллар босгоогүй.

Гэхдээ хий хоосон хүү төлж, цаг хугацаа алдахаас сэргийлж Засгийн газар бондоос дэд бүтцийн төслүүдэд санхүүжилт олгосон тал бий. Ерөнхий сайд Н.Алтанхуяг “Бондын мөнгийг бид халамж болгон хавтгайруулж тараагаагүй. Харин зайлшгүй шаардлагатай авто зам, төмөр зам, үйлдвэржилтэд зарцуулж байна” хэмээн мэдэгдсэн. Бондын хөрөнгийг

Чингис бондоор санхүүжүүлэх төслүүд

| | Төслийн нэр | Чингис бондоор санхүүжүүлэх хэмжээ сая ам.доллар | Засгийн газрын тогтоолын дугаар |
|----|--|--|---------------------------------|
| 1 | Тавантолгой цахилгаан станц төсөл | 50.0 | 80 |
| 2 | “Гудамж” төсөл | 200.0 | 81 |
| 3 | Шинэ төмөр зам” төсөл | 200.0 | 82 |
| 4 | “Аймгийн төвүүдийг Улаанбаатар хоттой хатуу хучилттай замаар холбох төсөл” | 101.2 | 96 |
| 5 | Нийслэлийн орон сууцны дэд бүтцийг сайжруулах төсөл | 141.8 | 118 |
| 6 | Ноолууран бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарын техник тоног төхөөрөмжийг шинэчлэх | 68.5 | 126 |
| 7 | Сүү, сүүн бүтээгдэхүүний үйлдвэр | 27.7 | 141 |
| 8 | Өвлийн хүлэмж барих | 17.4 | 141 |
| 9 | Ноосон бүтээгдэхүүний үйлдвэр | 45.0 | 141 |
| 10 | Оёмол бүтээгдэхүүний салбар | 13.5 | 141 |

ухаалаг зарцуулсан эсэхийг цаг хугацаа харуулах биз.

“Чингис” бонд гаргаж байх үед санхүүжүүлэхээр зэхсэн томоохон төслүүдийн аль ч нь урагшаа алхам хийсэнгүй. Тухайлбал, Сайншанд аж үйлдвэрийн цогцолбор, Газрын тос боловсруулах үйлдвэрийг дурдаж болох юм. 1.5 тэрбум ам.доллар нь ДНБ-ий 17 хувьтай тэнцэх мөнгө.

Одоо Засгийн газарт шинээр 3.5 тэрбумын бонд гаргах эрх бий. Гэхдээ наана нь Чингис бондоос үлдэж буй 360 сая ам.долларыг “чулуу” болгож чадахгүй бол юун бонд гаргах. Хариуцлагын асуудал энд хөндөгдөх нь дамжиггүй. Гадаадын шууд хөрөнгө оруулалтын хэмжээ огцом багассан. Эрдэс түүхий эдийн үнэ савалгаатай. Оюутолгойн далд уурхайн асуудал сунжирсан. Ийм цагт эхний ээлжинд 500 сая ам.долларыг бэлнээр төлөх боломж улам хомсдож байна.


Засгийн газрын тогтоолоор бондын хөрөнгөөр хийх ажлын жагсаалтыг гаргасан. Гэвч удаа дараа тогтоолд ▶

Төслүүдийг үнийн саналаар нь үзүүлбэл


| Үнийн дүн тодорхойгүй | 12 |
|-----------------------------------|-----|
| 500 саяас бага дүнтэй төсөл | 381 |
| 500 саяас 50 тэрбум хүртэлх төсөл | 728 |
| 50 тэрбумаас их дүнтэй төсөл | 30 |

Төслүүдийн хөрөнгө оруулалтын нийт үнийн санал нь 9.8 их наяд төгрөг
Хамгийн бага үнийн саналтай төсөл нь 8.2 сая төгрөг
Хамгийн өндөр дүнтэй нь 650.0 тэрбум төгрөг


Экспортыг дэмжих төслүүдийн байдал



Төслүүдийн байдал



Импортыг орлох төслүүдийн байдал




► нэмэлт, өөрчлөлт орсон нь “бантан” хутгасан тал бий. Тухайлбал, “Буянт-Ухаа” орон сууц хорооллын барилгын ажилд зориулан 50 тэрбум төгрөгийн санхүүжилтийг Хөгжлийн банкаар дамжуулан “Чингис” бондоос олгосон. Мөн “Байшин үйлдвэрлэх комбинатын төсөл”-д долоон сая ам.долларыг бондоос шилжүүлсэн. Засгийн газрын 256 дугаар тогтоолоор барилгын арматурын үйлдвэрийг барьж байгуулахад 50 сая ам.доллартай тэнцэх хөрөнгийн эрх өгсөн.

Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж бондын мөнгө манай улсын дансанд орж ирсэн өдөр “Монгол Улс хариуцлагатай улс

болох ёстой. Улсынхаа нэр хүндээр дэнчин тавьж авч буй өр” гэдгийг хэлж байсан. Мөн Засгийн газрын үнэт цаасны зарцуулалт, эргэн төлөлт, тавих хяналтад шаардагдах эрх зүйн орчинг бүрдүүлэх талаарх тодорхой чиглэлийг холбогдох албаны хүмүүст өгч байв. Энэ дотроо хариуцлагын асуудлыг их тодорхой зааж өгөхийг онцолсон. Мөн үүсч болох эрсдэлийг тооцож, эрсдэлийн удирдлагын механизмыг бүрдүүлэх бодлогын зөвлөл байгуулж ажиллахыг Ерөнхийлөгч Засгийн газар, УИХ-д даалгасан. Гэвч Ерөнхийлөгчийн үгийг үйлдэл болгосонгүй. Одоо яах вэ. ■

Төслүүдийг чиглэлээр нь ангилбал



СУДАЛГАА

ЧИНГИС БОНДЫН ЗАРЦУУЛАЛТЫН ЭДИЙН ЗАСГИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ НЬ

3. МАНЛАЙБААТАР

(/Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэн/)

Монгол Улсын Засгийн газар 2012 оны 12 дугаар сард 5 жилийн хугацаатай, 4.13 хувийн хүүтэй 500 сая ам.долларын болон 10 жилийн хугацаатай, 5.13 хувийн хүүтэй 1 тэрбум ам.долларын бондыг олон улсын зах зээл дээр худалдаж, дэд бүтэц, аж үйлдвэрийг хөгжүүлэх төслүүдийг санхүүжүүлж эхлээд байна.

Төлөвлөж буй энэ зарцуулалтын Монголын эдийн засагт үзүүлэх үр нөлөө урт хугацаандаа ямар байх вэ, уг хөрөнгө оруулалтыг олон салбарт хувааж хийхийн оронд хамгийн үр өгөөжтэй нэг салбарт төвлөрүүлж хийсэн бол урт хугацааны үр өгөөж ямар байх вэ гэдгийг Эдийн засгийн судалгаа, эрдэм шинжилгээний хүрээлэнгийн судлаачид Тооцоолох Ерөнхий Тэнцвэрийн (CGE) загвар ашиглан үнэлсэн юм.

Хоёр хувилбараар хийсэн судалгааны үр дүнг танилцуулахын өмнө судалгаанд ашигласан CGE

загварын талаар товчхон тайлбар хүргэе. Уг загвар нь дэлхийн бүх бүс нутаг, улс орны эдийн засгийн бүх салбарын харилцааг салбар хоорондын тэнцлийн тусламжтайгаар нэгтгэн тооцдог. Аль нэг зах зээлд гарч буй өөрчлөлт эдийн засагт оролцогчдын оновчтой шийдвэрийн дүнд бусад зах зээл рүү хэрхэн шилжиж ерөнхий тэнцвэрт нөлөөлдгийг судалдаг. Дэлхийн улс орнууд CGE загварыг ашиглан эдийн засгийн бодлогын үр нөлөө хүссэн үр дүнд хүрэх эсэхийг урьдчилан тооцдог. Мөн том төслүүдийн эдийн засагт ►►

үзүүлэх нөлөөг үнэлэх, ямар нэг бодлого, төсөл хойшилбол эдийн засагт ямар нөлөө үзүүлэхийг тооцох зэрэгт өргөн ашигладаг. Бидний ашиглаж буй загвар бол MINCGEM гэх уул уурхайн онцлогийг тусгасан хувилбар юм. Бусад загварын адил эдийн засгийн сонгодог онолд үндэслэсэн олон мянган тэгшитгэлийн системээс бүрдэх ба тусгай программ хангамжийн тусламжтайгаар ерөнхий тэнцвэрийг тооцоолдог.

Бодлогын үнэлгээ хийхдээ эхлээд тухайн бодлого хэрэгжээгүй байх үеийн эдийн засгийн тэнцвэрт үр дүнг тооцдог. Үүнийг суурь хувилбар (base scenario) гэж нэрлэнэ. Дараа нь загварт бодлогын өөрчлөлтийг (policy shock) оруулдаг. Ингэснээр бодлого хэрэгжих үеийн эдийн засгийн тэнцвэрт үр дүнг гаргаж авна. Үүнийг бодлогын хувилбар гэнэ (policy case). Эцэст нь, бодлогын ба суурь хувилбараа харьцуулж, тухайн бодлогын үр нөлөөг эдийн засгийн салбаруудаар, хүчин зүйлсээр, улс орнуудаар, урт богино хугацаагаар гэх мэт нарийвчлан тодорхойлдог.

Хувилбар 1. Чингис бондын өнөөгийн зарцуулалтын эдийн засгийн үр нөлөө

Аливаа загвараар үнэлгээ хийхэд урьдчилсан нөхцөл шаардлагатай. Бид үнэлгээндээ дараах урьдач нөхцөлүүдийг дэвшүүлсэн. Тухайлбал суурь хувилбарыг үнэлэхдээ:

- Оюутолгой, Тавантолгой гэх мэт уул уурхайн томоохон төслүүд олон нийтэд зарласан анхны төлөвлөгөөнийхөө дагуу амжилттай хэрэгжинэ

- Эдийн засгийн бусад салбар өнөөгийнхөө инерцийг хадгалан хөгжинэ
- Бусад орны болон Монголын эдийн засагт өөр гэнэтийн том өөрчлөлт тохиолдохгүй

Харин бодлогын хувилбарыг үнэлэхдээ дараах нөхцөлүүд дэвшүүлсэн. Үүнд:

- 2013-2014 онд авто замын салбарт 648 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгдэж, хот хөдөөд нийт 2365 км хатуу хучилттай зам баригдана. Зам баригдсанаар худалдаалагдах салбаруудын өртөг буурна.

- 2013-2014 онд хөнгөн аж үйлдвэрийн салбарт 280 сая ам.долларын хөрөнгө оруулалт хийгдэнэ. Ингэснээр уг салбарын үйлдвэрлэл ба экспорт ялимгүй нэмэгдэнэ.


- 2013-2016 онд Тавантолгойн уурхайг түшиглэн 450 мВт-ын дулааны цахилгаан станц барина. Үүнд шаардагдах 893 сая ам.долларын хөрөнгө оруулалтын 50 саяыг Чингис бондын хөрөнгөөс, 254 саяыг Засгийн газраас, үлдэх 66 хувь буюу 589 саяыг гадаадын хөрөнгө оруулалтаар бүрдүүлнэ. Цахилгаан станц 2017 онд ашиглалтад орсноор эрчим хүчээ Хятад улсаас импортолж буй Оюутолгойн уурхайг эрчим хүчээр бүрэн хангана.

- 2013-2015 онд Тавантолгойгоос Гашуунсухайт хүртэл 267 км төмөр зам барьж Тавантолгойн нүүрсийг тээвэрлэнэ. Үүнд шаардагдах 650 сая ам.долларын 200 саяыг Чингис бондын хөрөнгөөс, 132 саяыг Засгийн газраас, үлдэх 49 хувь буюу 319 саяыг гадаадын хөрөнгө оруулалтаар бүрдүүлнэ. Төмөр зам баригдсанаар Таван толгойн нүүрсийг хил хүртэл тээвэрлэх өртөг буурна.


- Чингис бондын хүү болон үндсэн өрийг хуваарийн дагуу буцааж төлнө.

Чингис бондын өнөөгийн зарцуулалтын үр дүнг 2030 он хүртэл нэгтгэж харвал нийт эдийн засагт 36 их наяд орчим төгрөгийн эерэг нөлөө үзүүлэхээр байна. 2017 он хүртэлх

Бодит ДНБ 2012, их наяд төгрөгөөр



Суурь хувилбараас хазайх хувь



барилгын үе шатанд ДНБ-ий 7-8 хувьтай тэнцэх нөлөө үзүүлнэ (ойролцоогоор 50 хувь нь шууд бус нөлөө).

Богино хугацаанд барилгын салбарт томоохон нөлөө үзүүлэхээс гадна дунд болон урт хугацаандаа тээвэр, цахилгаан эрчим хүч, уул уурхайн салбарын өсөлтөд чухал нөлөө үзүүлнэ. Харамсалтай нь ХАА, аж үйлдвэрийн салбарын өргөжилтөд төдийлөн нөлөө үзүүлэхгүй.


Чингис бондын өнөөгийн зарцуулалтын үр дүнд импорт огцом нэмэгдэнэ. Тиймээс суурь хувилбараар 2016 оноос гадаад худалдаа ашигтай гарч эхлэх байснаа бүтэн жилээр хойшилж байна. Гэхдээ урт хугацаандаа гадаад худалдааны ашиг суурь хувилбарт тооцсноос өндөр байна.

Үүнтэй холбоотойгоор төгрөгийн ханш Чингис бонд гаргаагүй байсан үетэй харьцуулахад 5-8 хувь чангарах хандлагатай байна.


Ирэх 18 жилийн хугацаанд Чингис бондын хөрөнгө оруулалтын үр дүнд өргөжих бизнесээс Монголын Засгийн газар 20 их наяд орчим төгрөгийн нэмэлт татварын орлого бүрдүүлэхээр байна. Хэдийгээр Чингис бондын хөрөнгө оруулалт төсвөөс гадуур зарцуулагдаж байгаа боловч эргэн төлөлтийг төсвөөс хийнэ. Энэ нь төсөвт түр зуур нэлээд хүндрэл үзүүлэхээр байна.

Эцэст нь, бид Чингис бондын хөрөнгийг зарцуулж байгаа дөрвөн салбарын аль нь илүү үржүүлэгч үр нөлөөтэй байгааг харьцуулж судалсан. Ингэхэд, төмөр замд хийсэн


Худалдааны тэнцэл (2012 он/ их наяд төгрөгөөр)



Валютын бодит ханш 2012=1



Төсвийн тэнцэл (%GDP)



- ▶ хөрөнгө оруулалт 2013-2030 оны хугацаанд 17.5 дахин их, Цахилгаан станц 8.9 дахин, авто зам 7.3 дахин, аж үйлдвэр 3.2 дахин их нэмэгдсэн өртөг бий болгохоор байна. Өөрөөр хэлбэл, хамгийн их үржүүлэгчтэй салбар нь төмөр зам байна. Иймээс бид Чингис бондын хөрөнгийг төмөр замын бүтээн байгуулалт руу оруулбал эдийн засагт ямар нөлөө үзүүлэх вэ гэдгийг тусад нь авч үзсэн юм.

Хувилбар 2. Хөрөнгө оруулалтыг дан ганц төмөр замд төвлөрүүлэх хувилбарын үнэлгээ

Энэ тооцооны үнэлгээ нь өмнөх хувилбартай яг ижилхэн суурь хувилбарыг авч үзсэн. Өөрөөр хэлбэл, уул уурхайн томоохон төслүүд олон нийтэд мэдээлсэн төлөвлөгөөнийхөө дагуу хөгжих ба бусад салбар өнөөгийнхөө инерцийг хадгална гэж үзсэн. Харин бодлогын хувилбар дээр бид Засгийн газар Чингис бондын 1.5 тэрбум ам.долларын хөрөнгийг бүгдийг нь зөвхөн төмөр зам барихад зарцуулна гэж үзсэн. Ингэхдээ шинэ төмөр замын 51 хувийг төр эзэмших. Харин үлдэх 49 хувийг гадаад, дотоодын хувийн хөрөнгө оруулагчдад санал болгох замаар 1.44 тэрбум ам.долларын хөрөнгө оруулалт нэмж татах. Нийт 2.9 тэрбум ам.доллараар 1200 км төмөр зам барина. Үүгээр Тавантолгой-Гашуунсухайт, Тавантолгой-Сайншанд-Хөөт-Рашаант, Нарийн сухайт-Шивээ хүрэн, Чойбалсан-Хөөт-Бичигт гэх мэт чиглэлд өргөн төмөр зам барьж, 18 жилийн хугацаанд 2.6 тэрбум тонн уул уурхайн болон бусад ачаа зөөвөрлөнө гэж үзсэн. Харин Тавантолгойн цахилгаан станц баригдахгүй, Улаанбаатар хот доторх болон аймгийн төвүүдийг холбосон замууд баригдахгүй, аж үйлдвэрийн салбарт Чингис бондоос төлөвлөж байгаа хөрөнгө оруулалт хийгдэхгүй гэж үзсэн.

Ингэж загварчлахад гарсан үр дүнг товч дурдвал, нийт эдийн засагт бүтээгдэх нэмэгдсэн өртөг Чингис бондын өнөөгийн зарцуулалтын хувилбараас хоёр дахин их байна. Өөрөөр хэлбэл, 2012 оны үнээр тооцоход 71 орчим их наяд төгрөгийн нэмэлт өртөг бүтээгдэж байна. Үүний гол шалтгаан нь худалдаалагдах салбаруудын бүтээгдэхүүний өртөг буурахтай холбоотой. Шууд ба шууд бус үр нөлөө нь ойролцоо. Барилгын салбарт эхэн үедээ эерэг нөлөө үзүүлэх ч урт хугацаандаа үр нөлөө нь эрс буурна. Харин эрчим хүчний салбарт бүх хугацааны туршид сөрөг үр дүн үзүүлэхээр байна. Бусад салбарт 23-70 хүртэлх хувийн өсөлт авчрахаар буй.

Худалдааны тэнцэл эерэг гарч эхлэх хугацаа нэлээд хойшилж 2019 он болж байгаа. Гэвч түүнээс хойшоо худалдааны ашиг бусад хувилбараар тооцноос илүү байна. Үүнтэй холбоотойгоор хугацааны эцэст үндэсний валютын ханш Чингис бондын өнөөгийн зарцуулалтын хувилбартай харьцуулахад дөрөв орчим хувиар чангарахаар байна. Энэ хугацаанд Засгийн газар 6.7 орчим их наяд төгрөгийн татварын орлого илүү төвлөрүүлж, 2023 оноос хойш улсын төсөв байнга гурван хувийн ашигтай гарахаар байна.

Эцэст нь, бид дээрх тооцоог хийхдээ суурь хувилбараа нэлээд өөдрөг төсөөлсөн гэдгийг дахин дурдъя. Мэдээж суурь ба бодлогын шинжилгээг маш олон хувилбараар тооцож, үнэлэлт өгөх боломжтой. ■

ЖИЖИГ, ДУНД ҮЙЛДВЭРЛЭЛ

МОНГОЛ БЭЛЭГ

Э.ЗОРИГТ

Гаднын хүн орохыг хориглоно гэсэн бичигтэй хаалгыг зөөлөн тогшлоо. Ямар ч хариу алга. Хааяа нэг тог тог гэх чимээ дуулдах бөгөөд хаалганы ард ажил буцалж байгаа гэхэд итгэмээргүй. Хэсэг хүлээлээ. Тэсгэл алдан хаалгыг дахин тогшлоо. Хариуд нь өнөөх л тог тог гэх чимээ. Уулзах ёстой хүн рүүгээ утас цохьсон боловч хариу алга. Хүлээлт алдрахын даваан дээр ашгүй хаалгыг хэн нэгэн онгойлгов. Тийнхүү “Хас гоёл”-ын ертөнцөд орлоо. Чимээгүй хаалганы ард 20 гаруй хүн ямар нэг зүйлийг зүлгэж, зорж, зурж суусан аж. Ойртоод нэлээд харвал тэдний гарт байгаа үнэт чулуу, алт, мөнгө гоёмсог хэлбэрт орох нь сонихон. Өнөөх тог тог гэх чимээний хувьд мөнгөн аяга урлаж байгаа нэгэн дархны алх, дөшний чимээ байсан аж.

Чулуутай нөхөрлөсөн түүх

“Хас гоёл” ХХК-ийн ерөнхий захирал С.Батзоригт 1990-ээд оноос чулуутай “нөхөрлөсөн” нэгэн. 1985 онд Дүрслэх урлагийн дээд сургуулийг төгсч тэндээ зургаан жил орчим багшилсан аж. Зах зээлийн сургаар өөрийн хүсэл сонирхолд хөтлөгдөн хувь хүний захиалга авч төрөл бүрийн гар урлал, бэлэг дурсгал хийдэг болжээ. 2002 онд “Хас гоёл” компанийг үүсгэн байгуулсан гэнэ. Тэрбээр “Монгол гэхээр гаднынхан тийм ч сайн мэддэггүй. Тиймээс Монголын соёлын өвийг хөгжүүлэх, дэлхийн хэмжээнд таниулах зорилготой ажиллаж байна. Хэн ч харсан үнэ цэнэтэй, Монгол ахуй үнэртсэн тийм бэлэг дурсгалын зүйлс хийхийг чухалчилдаг” гэсэн юм. Тэд албан байгууллага, хувь хүний захиалгаар алт, мөнгө болон үнэт чулуун шигтгээ бүхий гоёлын эдлэл, бэлгэдэл, логог урлаг, гоо зүйн өндөр түвшинд хийдэг аж. Өдгөө байгалийн чулууны энерги, өвөрмөцдонж, бэлгэдлээс нь хамаарч төрөл бүрийн хэлбэрт оруулан сорьцын баталгаатай бүтээгдэхүүн гаргадаг. Сорьцын баталгаа гэдэг нь Сорьц хяналтын албанд бүртгэлтэй албан ёсны бүтээгдэхүүн гэсэн үг. Ер нь иргэд алт мөнгөний сорьцтой бүтээгдэхүүн авч байгаа бол сорьц болон үйлдвэрлэгчийн тэмдэглэгээтэй бүтээгдэхүүн авахыг хичээх хэрэгтэй. Үүнийг “Хас гоёл”-ын ажилчид хэлж байсан юм. Үйлдвэрлэгч нь тодорхойгүй хэрнээ алт, мөнгөний сорьцтой бүтээгдэхүүн хуурамч байх тохиолдол өндөр байдаг аж. “Хас гоёл”-ын дархчууд байгалийн цэвэр чулуун суурьтай, 925 сорьц бүхий сийлбэртэй морин хуурыг мөнгөөр урлажээ. Мөн марал буга, хүчит бөх, дөрвөн хүчтэнг урласан ховор сонин бэлэг дурсгалын зүйл олон. Мөн тэд орчин үеийнхний хэрэглээнд зохицуулан гар утасны зүүлт, лааны суурь гээд алт, мөнгөөр урлахгүй зүйл ховорхон.



“Хас гоёл” ХХК-ийн ерөнхий захирал С.Батзориг

Фотог Э.Зоригт

Шинэ зорилго

Тус компани одоогоор 30 гаруй ажилтантай. Сүүлийн 10 гаруй жил гар урлал, үнэт эдлэлийн чиглэлээр ажиллаж, Монголын зах зээлд хэдийнэ танигдсан “Хас гоёл”-ын хамт олон өдгөө өөр нэг зорилгын төлөө зүтгэж байна. Тэр нь гаднаас оруулж ирдэг хямд үнэтэй бэлэг дурсгалын зүйлсийг эх орондоо хийх юм. С.Батзоригт “Энгэрийн тэмдэг, түлхүүрийн оосор зэрэг бэлэг дурсгалын зүйлсийг заавал яагаад урд хөршид захиалж хийлгэх ёстой гэж. Монголд энэ талын технологи байхгүй. Эх загварыг гараар хийж болно. Гэтэл олшруулах гэхээр асуудалтай тулгардаг байсан. Хэдэн мянган ширхэг эд эдлэлийг бүгдийг нь гараар хийнэ гэдэг хүндрэлтэй. Хийж болох ч бүтээгдэхүүний үнэ өндөр болчихдог. Харин одоо бол өртөг багатай бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжтой болсон” гэсэн юм. Тус компани өнгөрсөн оноос цайрын хайлшин технологийг нэвтрүүлж, урд хөршөөс олшруулах технологийг нь оруулж ирсэн байна. “Хас гоёл” компанийн дархан Ч.Батбаяр “Цайран дээр хэр баргийн металл тогтодоггүй. Тиймээс цайран дээр өнгөлгөөний металл тогтоодог технологийг бид урдаас оруулж ирсэн. Мөн цайрын цутгуурын технологийг оруулж ирсэн. Энэ технологийн давуу тал нь бид энд бүх төрлийн бэлэг дурсгалыг үйлдвэрийн аргаар олноор үйлдвэрлэх боломжтой юм. Мөн тусгай төхөөрөмжөөр үйлдвэрлэж байгаа болохоор бүтээгдэхүүн үйлдвэрлэх зардал багасч үнэ харьцангуй хямд болсон” гэв. Урд нь зэс, гууль, мөнгөөр хийдэг байсан нэгж бүтээгдэхүүний үнэ 50-60 мянган төгрөгийн өртөгтэй гардаг байжээ. Харин одоо нэг бүтээгдэхүүн дунджаар 5-10 мянган төгрөгийн үнэтэй ▶

► болсон гэнэ. Цайр нь бага температурт хайлдаг. Мөн илүү урсамтгай. Алт мөнгийг бодвол хэд дахин хямдхан. Гэхдээ өнгөлгөө авдаггүй муу талтай байдаг аж. Өнгөлөх тусам харлаад байдаг нь сонин юм билээ. Тиймээс цайрыг өнгө оруулахдаа хэвлэж бэлдсэн цайраа зэсээр бүрээд дараа нь никельдэж өнгөлдөг аж. Ингэж өнгөлсөн бэлэг дурсгалын зориулалттай бүтээгдэхүүн өнгөө хадгалах чадвар сайн байдаг аж. Цэвэр мөнгө, эсвэл гуулиар хийсэн бэлэг дурсгалын бүтээгдэхүүн амархан харладаг. Байнга зүлгэж, өнгөлж байхыг шаарддаг. Харин хайлшин технологиор хийсэн бэлэг дурсгалын эдлэлийн хадгалалтын хугацаа удаан байдаг гэсэн үг аж. Гэхдээ сул тал бий. Одоогоор тэд хайлшаар хэрэглээний бараа бүтээгдэхүүн хийж эхлээгүй. Тэгээд ч хэрэглээний эдэлгээ даах чадвар муутай байдаг гэнэ. Хэрвээ урдаас өндөр даралтаар шахдаг технологийг нь оруулаад ирвэл бүтээгдэхүүн хийх орц найрлага нь адилхан учраас эдэлгээ даадаг бүтээгдэхүүн үйлдвэрлэх бүрэн боломжтой гэсэн. Гэхдээ зах зээлээ сайн судлахгүй бол болохгүй. Учир нь Монголын зах зээлд 10 бүтээгдэхүүн гарлаа гэхэд ердөө нэг юм уу хоёр нь л "амьдардаг" аж. Ийм технологи өнөөдрийг хүртэл Монголд орж ирэхгүй байсан гол шалтгаан нь нэгд зах зээлийн судалгаа бага. Мөн энэ нь өндөр технологи болохоор маш том үйлдвэрт л ашигладаг юм байна. Тиймээс тоног төхөөрөмжийн өртөг нь өндөр. Өөрийн өртгөө нөхөхөд хүндрэлтэй байдаг аж. Гэхдээ "Хас гоёл"-ынхон энэ технологийг аль болох жижигсгэж, зарим зүйлийг нь монголчилжээ.



Монгол Улсын Ерөнхий сайд асан С.Батболдын гарын бэлэг

Өрсөлдөөн

Хямдхан бас чанартай бүтээгдэхүүн хийлээ гээд өмнөд хөрштэй өрсөлдөхөд хэцүү. Цайрын хайлшин технологи гэхэд л Хятадад хөгжөөд хэдийнэ өндөр түвшинд хүрчихсэн. С.Батзориг "Хятадад бидэнтэй адилхан өч төчнөөн гар урчууд байдаг юм билээ. Гэхдээ тэдний хувьд өнгөлгөө хийлгэхдээ үйлдвэрт аваачаад л өгчихдөг. Ер нь аль ч оронд эцсийн бүтээгдэхүүн гаргадаг томоохон үйлдвэр байдаг. Тэр үйлдвэрт хэв, цутгамал бүтээгдэхүүн нийлүүлдэг гээд тус тусдаа хүмүүстэй. Нэг нь модель хийж байхад нөгөө нь тэнд хэвээ авч байдаг. Түүнийг нь нөгөө нэг нь цутгадаг. Түүнийгээ өнгөлгөөний үйлдвэртээ аваачаад өнгөлдөг гэх мэт бүгдээрээ нийлж байж сая эцсийн бүтээгдэхүүн хийдэг. Тэгсэн мөртлөө дор бүрнээ ашигтай ажиллаж чаддаг тогтолцоо олон улсад хэдийнэ бий болчихсон" гэв. Гэтэл Монголд тийм биш. Ганц хүн л бүх зүйлийг дангаараа хийдэг. Өөрөө загвараа гаргана, цутгана, өнгөлнө. Энэ нь нэг талаар эрсдэлтэй. Үйлдвэрлэлийнхээ нэг хэсэгт л гологдол гаргавал тухайн үйлдвэрлэгч маш том алдагдалд ордог. Гэтэл Хятадад тийм биш. Хэрвээ ч цутгамал үйлдвэрлэхдээ алдаа гаргасан бол ердөө цутгамлаа буруу хийсэн эрсдэлээ л үүрнэ. Нөгөө олон хэвлэх, өнгөлөх гэх мэт дагалдах эрсдэлийг үүрэхгүй. Харин Монголын үйлдвэрлэгчид энэ бүх эрсдэлийг дангаараа үүрч байна. Тэр хэрээр бүтээгдэхүүний үнэ өсдөг аж. Ер нь урд хөрштэй үнээр өрсөлдөнө гэдэг хэцүү гэдгийг дотоодын үйлдвэрлэгч бүр л хэлдэг. Хятадууд хямд түүхий эдийн орчинтой. Дээрээс нь ажиллах хүч нь харьцангуй хямд гээд тэдэнд давуу тал олон. Гэтэл Монголд үйлдвэрлэл явуулахын тулд Хятадаас түүхий эдээ оруулж ирдэг. Тээврийн зардал, гаалийн татвар нэмэгдэхийн хэрээр дотоодод үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн Хятадын бүтээгдэхүүнээс 10 орчим хувиар үнэтэй болчихдог аж. Үйлдвэрлэгчдийн хувьд түүхий эд гээд байгаа боловч тэр нь бас уурхайгаас олборлосон анхдагч түүхий эд биш. Монголчуудын хувьд анхдагч түүхий эдээ урагшаа гаргадаг. Түүнийг нь Хятадууд боловсруулаад хоёрдагч түүхий эд болгодог. Үүнийгээ үйлдвэрлэгчид өндөр үнээр худалддаг. "Хас гоёл" компанийн хувьд өмнө нь жижиг бэлэг дурсгалын зүйлийг 20-30 мянган төгрөгөөр хийдэг байсан бол одоо 2-3 мянган төгрөгөөр хийж болохоор болсон. Тэдний хувьд таван жилийн өмнөх үнээ нэмээгүй ч дунджаар 5-10 дахин хямдруулсан. Уг нь юанийн үнэ өсөөгүй бол бүтээгдэхүүнийх нь үнэ үүнээс ч илүү хямдхан байх боломжтой байжээ. Гэтэл урдаас орж ирдэг түүхий эд, жааз, будаг гээд үйлдвэрлэлд хэрэгтэй бүх зүйл нь өдөр ирэх тутам л үнэтэй болоод байдаг. Тиймээс хямд түүхий эдийн орчин, үйлдвэрлэлийн цогц механизмыг Монголдоо бий болгохгүй бол "Made in Mongolia" "Made in China"-тай өрсөлдөхөд улам л хэцүү болсоор. ■

БИЗНЕСМЭНИЙ ДУУ ХООЛОЙ

БИДНИЙ ӨМНӨ ГУРВАН ТЭРБУМЫН ЗАХ ЗЭЭЛ БАЙНА



Э.ЗОРИГТ

“НоваТерра” компанийн захирал Б.Бямбасайхантай энэ оны эдийн засгийн өнгө болон бизнесийн орчны талаар ярилцлаа.

-Нэгэн үе “Ньюком”-оор овоглож байсан Бямбасайхан өдгөө “НоваТерра” гээд шинэ компанийн захирал болжээ. Та компанийнхаа талаар товч танилцуулахгүй юу?

-2013 онд бие биенээ ойлгодог, санхүү, менежментийн туршлагатай хүмүүстэй нийлж “НоваТерра” компанийг үүсгэн байгуулаад ажиллаж байна. Манай компани хөрөнгө оруулалт, төслийн менежмент гэсэн хоёр үндсэн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг. Өнгөрсөн онд манай компанийн хувьд хэд хэдэн төсөл дээр амжилттай ажилласан. Тэр дундаа үйлдвэрлэлийн төсөл дээр хүртэл санхүүжилт босгож чадлаа. Стандартын дагуу ажлаа хийвэл, хөрөнгө мөнгө босгож болж байна.

Эдийн засгийн өндөр өсөлтийг дагаад ойрын 10-15 жил барилга, дэд бүтэц, эрчим хүч, усан хангамжийн чиглэлээр томоохон бүтээн

байгуулалт хийгдэхтэй холбоотойгоор бидэнд олон улсын стандартын дагуу ажиллах шаардлага тулгарч байгаа. Энэ шаардлагын дагуу олон улсын томоохон, нэр хүндтэй инженерингийн чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг “Mott MacDonald” компанитай хамтын ажиллагаагаа Монголд эхлүүлсэн.

-Өнгөрсөн оны эдийн засгийн байдал тийм ч таатай байсангүй. Гэхдээ л ДНБ 12 хувийн өсөлттэй гарсан. Тэгвэл энэ онд эдийн засгийн нөхцөл байдал ямар байх бол?

-Өнөөдрийн Монголын зах зээл дэлхийд ховорхонд тооцогдож байна. Учир нь манай эдийн засаг тогтмол өсөлттэй явж байгаа. Цаашдаа ч энэ өсөлт хадгалагдахаар байна. Ойролцоогоор 10-15 жилд эдийн засгийн өсөлт буурахгүй төлөвтэй. Тухайлбал, “The Economist” сэтгүүлд энэ онд манай улсын эдийн засгийг олон улсад хамгийн өндөр өсөлттэй буюу 14 орчим хувь байхаар төсөөлсөн байсан.

-Эдийн засаг өсөхийн хэрээр яригдаж байгаа нэг зүйл бол олон улсын хэмжээнд ажиллах шаардлага бидний өмнө тулгамдаж байна. Энэ шаардлагыг Монголын компаниуд биелүүлж чадаж байна уу?

-Бизнес явуулах таатай орчин зарим талаараа бүрдсэн гэсэн үг. Тиймээс олон улсын стандартын дагуу бизнесээ явуулах бол бизнесийн амжилтын суурь боллоо. Гэхдээ бид санхүүжилтын эсвэл инженерингийн чиглэлийн тодорхой стандартыг шинээр бий болгох гээд байх хэрэггүй. Харин бэлэн байгааг нь шууд аваад ашиглах боломж нээлттэй байна. Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн стандарт, дүрэм журмыг дагаж мөрдөх нь нэг талдаа хөрөнгө оруулагчдын итгэлийг олох гол арга зам. Нөгөө

талдаа тухайн бүтээн байгуулалтын ажлыг төлөвлөсөн хугацаанд нь дуусгах чадавхийг нэмэгдүүлдэг. Өнөөдөр бид зөвхөн гурван сая хүн амтай зах зээлд өрсөлдөөгүй. Харин Хятад, Орос, Энэтхэг тэргүүтэй гурван тэрбум давсан хүн амтай асар том зах зээлд ажиллаж байна. Ийм том зах зээлд олон улсын стандартын дагуу ажиллахгүй л бол оршин тогтноход хэцүү.

-Статистик мэдээллийг харахад муу мэдээ олон байна. Ойрын хугацаанд эдийн засаг бидний төсөөлж байсан шиг сэргэхгүй л болов уу. Энэ талаар бизнес эрхлэгч хүний хувьд ямар хүлээлттэй байгаа вэ?

-Өнгөрсөн онд бид амжилттай ажилласан. Эдийн засаг уналттай байна гээд зүгээр сугаад байж болохгүй. Эерэг талаас нь харвал хууль эрх зүйн хүрээнд бизнесийн орчныг дэмжих хэд хэдэн хууль батлагдлаа. Засгийн газраас бизнесийн орчныг сайжруулахад анхаарч эхэллээ. Ухаалаг төрийн хувьсгал эхэлсэн. Тиймээс энэ онд эдгээр ажлын үр дүн гарах байх. Үр дүн юугаар хэмжгдэх вэ гэвэл бизнесийн хүрээнд ашиг орлого нэмэгдэх. Энэ хэрээр олон хүн ажлын байртай болно. Ажлын байр нэмэгдэх тутам баталгаат орлоготой иргэдийн тоо олширно. Ингээд нийт улсын хэмжээнд амжиргааны түвшин сайжирна. Цаашдаа монгол хүн эх орондоо хүссэн мэргэжлээрээ ажиллаж сайхан амьдрах боломж бүрдэх юм. Ер нь бол бид өөрсдөө л хичээхгүй бол эдийн засаг өсөхгүй. Харин эдийн засаг өсөхгүй бол монгол хүний амьдрал сайжрахгүй. Эзэн хичээвэл заяа хичээнэ гэдэг дээ. Түүнээс биш хэн нэгэн шидтэн гарч ирээд бүх зүйл сайхан болчихгүй. ▶▶

► Үүнтэй холбоотой хариуцлага гэдэг ойлголт гарч ирнэ. Хувь хүн, бизнесийн үйл ажиллагаа явуулж байгаа компани бүр хариуцлагатай байж чадвал амьдралын түвшин дээшилж, тухайн байгууллага илүү ашигтай ажиллана. Тэр цагт эдийн засаг бидний хүсээд байгаа шиг өсөх нь дамжиггүй.

-Хариуцлага. Энэ талаар хаа сайгүй ярьдаг ч манайхан хариуцлагаас зугатаж бултах нь их. Энэ ойлголтын талаар та юу хэлэх вэ?

-Хариуцлага гэдэг бол аливаа ажлыг эхлүүлсэн л бол заасан хугацаанд нь чанартай дуусгах явдал юм. Нөгөө талдаа ухаалаг төр гэж яриад байгаа маань хариуцлагатай байх тухай л асуудал юм шүү дээ. 2050 он гэхэд долоон сая иргэнтэй болж дундаж наслалтаа нэмэгдүүлье. ДНБ-ээ 380 тэрбум ам.долларт хүргэе. Нэг хүнд ногдох ДНБ-ийг 55 мянган ам.долларт хүргэх, хөрөнгө оруулалтын хувьд ААА зэрэглэлтэй болох гээд олон зорилгыг онцлон Ерөнхийлөгч ухаалаг төрийн талаарх илтгэлдээ дурдсан. Энэ бүхэн боломжгүй зүйл биш. Магадгүй хичээвэл 2050 оноос ч өмнө эдгээр зорилтод хүрч болно. Үүний тулд л хүн бүр миний түрүүний дурдсан хариуцлагатай буюу цагийн юмыг цагт нь олон улсын стандартын дагуу хийдэг болох хэрэгтэй.

Мөн манай улс хуулийн засаглалын тухайд бүс нутагтаа манлайлагч болмоор байна. Хуулиа дээдэлдэг байх нь чухал. Энэ чинь бас л нэг төрлийн хариуцлагын тогтолцоо шүү дээ. Монголтой адилхан далайд гарцгүй жижиг орон болох Швейцарь өнөөдөр яагаад өрсөлдөх чадвараараа дэлхийд тэргүүлж байгаа юм бол. Тэгвэл Монгол Улс далайд гарцгүй хэдий ч гурван тэрбум гаруй хүнтэй том зах зээлийн дунд байдаг асар их баялагтай орон байж яагаад дэлхийн тэргүүлэх улс болж болохгүй гэж. Боломж байгаа юу гэвэл байгаа. Тиймээс тэр зүг рүү л олуулаа хамтдаа алхана. Гурван сая хүн бүгдээрээ нэгдэж нийлээд энэ том зорилгын төлөө хамтдаа хөдөлмөрлөнө. Утааг бууруулна гээд л байдаг. Энд хэн нэг нь нийгмийн өмнө хүлээсэн хариуцлагаа ухамсарлаад аль болох утаа гаргахгүйг хичээгээд байлаа гэж бодъё. Гэтэл тэнд байгаа нэг нөхөр тааралдсанаа түлээд утаа гаргаад байж болохгүй биз дээ. Ийм сэтгэхүйтэй байвал бид утаанаас салахгүй. Хамгийн гол нь яндангийн

утаанаасаа түрүүлээд сэтгэлгээний угаараа л арилгах хэрэгтэй. Бизнес ч гэсэн ялгаагүй. Дор бүрнээ жижиг ашиг хараад суух биш Монгол Улсын эдийн засгийн өрсөлдөх чадвар буюу өсөлтийн төлөө нэгдэж байж бид мөрөөдөөд байгаа хөгжилд хамтдаа хүрнэ.

-Та Монголын Бизнесийн зөвлөлийн тэргүүн. Өөрөө ч залуу бизнесмэн. Тэгвэл өнөөдөр бизнесмэнүүд чухам юу хүсч байна вэ?

Хариуцлага гэдэг бол аливаа ажлыг эхлүүлсэн л бол заасан хугацаанд нь чанартай дуусгах явдал юм

-Монголын Бизнесийн зөвлөл 280 гаруй гишүүн компанитай. Эдгээр компанийн удирдлага болон ажилчдын хүсдэг гол зүйл нь хууль эрх зүйн орчин нь тогтвортой, тодорхой байгаасай л гэдэг. Тогтвортой, тодорхой хууль эрх зүйн орчин нь бүрдчихвэл тухайн компани бизнес хийгээд ашгаа олоод, татвараа төлөөд, ажлын байр бий болгоод явах тэмүүлэлтэй байна. Монголын компаниуд олон улсын стандартын дагуу ажиллаж чаддаг болсон. Өмнө нь компанийн эзэд аман гэрээ байгуулаад ойлголцоод ашигтай ажилладаг байсан сайхан цаг байсан. Учир нь аливаа бизнес чинь итгэл дээр тогтдог. Гэхдээ өнөөдөр бизнесийн цар хүрээ нь тэлж, өрсөлдөөн асар хурдтай нэмэгдсээр байна. Ийм нөхцөлд Монголын компаниуд олон улсын стандартад нийцсэн гэрээ хийх, тухайн гэрээний дагуу ажиллах ёстой болж байгаа юм. Хоёр тал гэрээ хийж байгаа тул харилцан ашигтай байх хэрэгтэй. Харилцан ашигтай ажиллах хэд хэдэн зарчим бий. Тухайлбал, зардал багатайгаар үр ашигтай, чанартай бүтээгдэхүүн үйлдвэрлэх чадавхитай менежменттэй байх. Мөн бүтээгдэхүүн үйлдвэрлэх эсвэл үйлчилгээ үзүүлэхдээ өндөр үр ашигтай технологи нэвтрүүлэх. Ингэж чадвал тухайн бизнесийн өсөх боломж нэмэгдэнэ. Гэхдээ анхаарах зүйл бий. Нөгөө капитализмыг морьтойгоо харайгаад алгассан гэдэг шиг технологийн хувьд үр ашиггүйг нь орхиод илүү дэвшилтэт шинэ технологийг шууд ашиглаад, менежментээ оновчтой болгож чадвал тухайн бизнес өндөр үр ашигтай

ажиллаж чадна.

-Та хэд хэдэн удаа олон улсын стандартын талаар дурдлаа. Тэгвэл бизнес явуулахад чухам ямар олон улсын стандарт барьж ажиллах ёстой вэ?

-Стандарт гэдэг өргөн хүрээтэй ойлголт л доо. Хэрвээ барилга барьж байгаа бол тодорхой стандарт, дүрэм журам гаргаад цаасан дээр батлаад бүх барилгын компани тэр дагуу л ажиллаад байж болно. Бизнесийн хувьд арай өөр. Бидний хамгийн их ярьдаг санхүүжилт босгох, хөрөнгө оруулалт татахын тулд хөрөнгө оруулагчдын итгэлийг олох хэрэгтэй. Ашигтай, ирээдүйд “чулуу” болох шинэ санаатай хүн монголоор дүүрэн. Гэхдээ хэчнээн сайхан санаатай байлаа гээд хэрэгжүүлэх арга зам нь тодорхойгүй бол ямар ч хэрэггүй. Хэн ч чамд итгэж хөрөнгө оруулахгүй. Хэрэгжүүлэх арга замаа тодорхой болгохын тулд хүн бүрийн итгэдэг, олон улсын хэмжээнд нийтлэг дагаж мөрддөг стандартын дагуу бүх материалаа бүрдүүлэх ёстой. Өнөөдөр олон улсын санхүүгийн компаниуд хүлээн зөвшөөрдөг стандартын дагуу бүх материалаа жин тан болгох нь хэн хэндээ амар. Мөн олон улсын хэмжээнд сэтгэх хэрэгтэй. Тэдэнтэй адилхан сэтгэж байж тэдний юу хүсч байгааг мэдэж авна. Дээр нь нэмээд тухайн гэрээ хийх гэж буй хүнтэйгээ бизнесийн хэлээр ярьдаг байх ёстой. Зөвхөн англи хэлээр ярьдаг байх нь бизнест хангалтгүй. Бизнесийн түншүүд биедээ итгэхийн тулд сайн ойлголцох ёстой шүү дээ. Сайн ойлголцохын тулд бид тухайн хөрөнгө оруулагчийн “төрөлх” буюу санхүүгийн хэлээр нь ярьж чадвал учраа олоход илүү хялбар байдаг. Энэ мэт бизнесийн түншийнхээ итгэлийг олохын тулд бид өөрсдөөсөө шалтгаалах бүх зүйлийг чанарын өндөр түвшинд хийх хэрэгтэй. Тиймээс бизнесийн хувьд чанар, стандарт гэдэг ойлголт нь маш өргөн хүрээг хамардаг. Хэрвээ энэ талаар сайн мэдэхгүй бол мэддэг чаддаг хүнээс нь асуугаад, сураад л явна.

-Гурван тэрбум хүнтэй зах зээл гэж байна. Монголчууд гадагшаа гарч өрсөлдөх талаар олон жил ярьж байгаа. Гэхдээ ажил хэрэг болсон нь цөөн. Компани олон улсын стандартын дагуу ажиллах хэрэгтэй гэлээ. Нөгөө талдаа дэлхийн зах зээлд өрсөлдөх чадвартай Монголын гэх тодотголтой бараа ►►

► Бүтээгдэхүүн байна уу?

-Өнөөдөр манай эдийн засгийн мотор яах аргагүй уул уурхайн салбар. Бид олон зүйл рүү зэрэг дайраад байвал хоосон хоцорч магадгүй. Тиймээс бид нэг зүйлийг л маш сайн хийх хэрэгтэй. Ингэж чадвал тэр өрсөлдөх чадвар юм. Энэ өнцгөөс нь харвал манай уул уурхайн салбарын бүтээгдэхүүн олон улсад өрсөлдөх чадвар өндөр байж чадна. Газар зүйн байршил болон нөөцийн чанарын хувьд харьцангуй сайн. Байгальд ээлтэй технологи нэвтрүүлж, сайн менежменттэй болж, байгалийн баялгаа зөв зохистой ашиглаж чадвал тус салбарын өрсөлдөх чадвар улам л нэмэгдэнэ. Зарим нэг нь уул уурхайг буруугаар ойлгодог. Гэхдээ уул уурхайн түүхий эдгүйгээр бий болдог бүтээгдэхүүн бараг байхгүй, өөрт байгаа гар утсаа л жишээлбэл харчих. Лондонгийн олимпын медиалийг Оюутолгойн зэс, алтаар хийсэн. Энэ бол маш чухал. Энгийнээр бодоход дэлхийн хэмжээний бүтээгдэхүүн үйлдвэрлэх түүхий эд нь Монголд байна шүү дээ. Тиймээс эхлээд байгаа зүйлээ зөв зохистой, ухаалаг ашиглаад сурчих хэрэгтэй. Түүнээс биш, тойрч суугаад хэрэлдээд байвал ажил урагшлахгүй. Уул уурхайн салбарт боловсруулах үйлдвэр, өндөр технологи нэвтрүүлээд үйлдвэрлэлээ явуулах хэрэгтэй. Түүнийхээ дараа өөр бусад бүтээгдэхүүнийг олон улсын зах зээлд нэвтрүүлэх боломж бидэнд олон бий. Гэхдээ өрсөлдөх чадвартай, сайн хийж чадах зүйлээ орхиод өөр зүйлийг хийх гээд байвал цаг хугацаа, хөрөнгө мөнгө их орно гэдгийг бодох хэрэгтэй. Нөгөө талаар уул уурхайг дагаад зам тээвэр, эрчим хүч тэргүүтэй том төсөл олон гарч ирж байгаа. Энэ төслүүдээ хэрэгжүүлснээр уул уурхайн өрсөлдөх чадвар сайжрахын зэрэгцээ бусад салбартаа том хувь нэмэр оруулна. Дэд бүтцийн том төслийг санхүүжүүлэхийн тулд гаднын зах зээлээс хөрөнгө босгох зайлшгүй шаардлагатай. Харин гаднын хөрөнгө оруулагчид монголчуудад итгэх үү? Тэдний итгэлийг олохын тулд нэн түрүүнд олон улсын зах зээлд өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүнтэй байх хэрэгтэй. Хөрөнгө оруулагч түүнд л итгэж хөрөнгө оруулдаг. Монголчуудын хувьд өнөөдөртөө өрсөлдөх чадвар бүхий бүтээгдэхүүн бол уул уурхайн баялаг шүү дээ. Хөрөнгө оруулагчдаас хөрөнгө босгож чадвал бид сургууль,

эмнэлэг, зам гээд хэрэгцээтэй байгаа бүтээн байгуулалтаа хийнэ. Ингэж чадвал иргэдийн амьдралын чанар сайжирна.

-Өнгөрсөн онд хэд хэдэн хууль шинээр гаргалаа, шинэчиллээ. Тухайлбал, Хөрөнгө оруулалтын тухай хууль байна. Энэ тухай маргаан өнөөдрийг хүртэл дуусаагүй л байна. Зарим нь Монголын төр шалдаа буучихлаа. Гаднынханд хамаг юмаа найр тавьж байна гэх. Энэ талаар таны бодол?

-Бид хүний төлөө юм хийгээгүй. Үүнийгээ л сайн ойлгох хэрэгтэй. Мөн монголчууд хэн нэгний өмнөөс амьдраагүй. Бид сүүлийн 20 гаруй жил ардчиллын замаар замнаад тодорхой үр дүнд хүрлээ. Өнөөдөр бидэнд эрх чөлөө байна. Хувийн өмчтэй боллоо. Хувийн өмчтэй, эрх чөлөөтэй болсноор бидний амьдрал сайжирсан. Гэхдээ хувийн өмч бий болоод эдийн засаг есөхийн хэрээр хуучин тогтолцоо, дүрэм журам өнөөдрийн байдалтай нийцэхгүй байна. Нийцэхгүй байгаа юмыг засч сайжруулах хэрэгтэй. 1990 оноос өмнө хуулиар зөвшөөрөөгүй л бол юу ч хийж болохгүй зарчимтай байсан. Харин одоо бид хүссэн зүйлээ хийж болно. Гэхдээ хуулийн хүрээнд ажиллах хэрэгтэй. Ийм л зарчмын өөрчлөлт гарсан гэж хэлж болно. Бизнесийн орчныг хөгжүүлэхийн тулд аль болох нээлттэй байх учиртай. Энэ нь хөрөнгөө оруулсан бол буцаагаад ашгаа хүртэж болдог тийм боломжийг бүрдүүлэх тухай асуудал юм. Нөгөө талдаа гэрээ хэлэлцээрээ дагаж мөрддөг байх. Хэрвээ талууд тохиролцож чадахгүй бол шүүхэд очоод хуулийн дагуу шийдвэр гаргуулах боломжтой байх хэрэгтэй. Үүний тулд л зарим нэг хуулийг өөрчлөх шаардлагатай байгаа юм. Зарим хүн хэлдэг л дээ "Сүүлийн 20 жил болсон болоогүй баахан хууль баталлаа" гэдэг. Тийм ээ, бид шилжилтийн үедээ л тохируулаад хууль дүрмээ баталж байсан юм байна. Өмнө нь чөлөөт зах зээлийн талаар ямар ч ойлголтгүй байсан улс гэнэт тийм нийгэмд хөл тавихаар арга ч үгүй биз. Дээр нь өнөөдрийг хүртэлх энэ хугацаанд илүү туршлагатай боллоо. Одоо бол бидэнд шилжилтийн биш харин өсөлтийг дэмжсэн, хувийн өмчийг жинхэнэ ёсоор хамгаалсан хуулиуд шаардлагатай болж байна.

-Гэхдээ зарим талаараа бизнесмэнүүдийг хэтэрхий

давраагаад байна гэдэг. Татвар их байна багасга. Ийм юм хийх гэж байна хөнгөл гэх шаардлагыг бизнесмэнүүд мөн гадаадын хөрөнгө оруулагчид хэлдэг. Зарим талаараа хэт давраад байгаа юм биш биз?

-Солиорол гэж байдаг даа. Альберт Эйнштэйн нэгэнтээ "Солиорол гэдэг бол нэг зүйлийг нэг аргаар олон дахин оролдоод өөр үр дүнд хүрэхийг хүлээх" хэмээн тодорхойлсон байдаг. Тухайлбал, энд хана байна заавал мөргөж гарна гээд байж болохгүй. Гэтэл тэр ханыг тойроод гарах боломжтой шүү дээ. Тиймээс бид аль болох л асуудлыг шийдэх олон арга зам хайх ёстой. Тэндээсээ хамгийн оновчтойг нь сонгож авах нь л чухал. Түүнээс биш даварсандаа энэ болохгүй байна, тэр асуудлыг шийдмээр байна гээд байгаа хэрэг огт биш. Эдийн засгийн өсөлтийг бизнес эрхлэгчид л авчирна. Тэгвэл бизнес эрхлэгчдэд Монголын хууль эрх зүйн орчин ойлгомжтой байхыг л шаардаж байгаа. Тогтвортой, ойлгомжтой байхыг л хүсч байгаа болохоос биш даварсан шаардлага тавиагүй. Өрсөлдөх чадварын нэг хэсэг нь ойлгомжтой орчинд бизнесээ төлөвлөж ажиллах. Тухайлбал, ийм татвар төлөх юм байна гэдгээ мэдэж байвал, бизнес хийхийн тулд ийм хэмжээний хөрөнгөөр тийм ашиг олох юм байна гээд төлөвлөгөө гаргаад түүнийхээ дагуу ажиллаж болно. Харин тэгээд зүтгэж байтал татварын орчин нь өөрчлөгдчихвөл тухайн бизнесийн үйл ажиллагаанд сөргөөр нөлөөлнө. Хөрөнгө оруулагчдын хувьд бидэнд итгэж хөрөнгө оруулдаг шүү дээ.

-Тэгвэл монголчуудын итгэл даах чадвар хэр байна вэ?

-Бидэнд сурах, шинээр нэвтрүүлэх зүйл олон байгаа. Цаашдаа ч байсаар байх болно. Өнөөдөр дэлхийн хамгийн том, өрсөлдөх чадвартай компани Apple ч гэсэн байнга л шинээр сурч, өөрчлөгдөхийг хичээсээр байдаг. Тэр хэрээрээ олон улсын зах зээлд итгэл даах чадвар нь дээшилдэг. Миний бодлоор Монголд шинэ санаа гаргаад түүнийгээ ажил хэрэг болгох боломж аль ч газраас илүү гэж боддог. Бидэнд боломж байна. Өөрсдөө л хичээх нь чухал. Байнга сайжирч, хариуцлагатай ажиллаж, олон улсын хэмжээнд сэтгэж чадвал монголчуудын өмнө гурван тэрбумын зах зээл нээлттэй байна. ■

ШИНЭ БИЗНЕС

ОВОО ХАРААНД “КАТЕРПИЛЛАР”

Ч.ЛУТАА

Уул уурхайн техникүүд зогсох эрхгүй. Техник томрохын хэрээр сул зогсолт гарахад тухайн уурхайд багагүй хэмжээний хохирол учруулдаг аж. Тухайлбал, Оюутолгой уурхай дөрвөн том экскаватортой. Нэг нь ажиллахаа болиход л үйлдвэрлэлийн 25 хувь нь зогсоно гэсэн үг. Энэ утгаараа уул уурхайн компанийн хувьд хамгийн чухал зүйл бол техник хэрэгсэл, сэлбэгийн бүрэн бүтэн байдал. Гэтэл Монгол Улсад энэ төрлийн засвар үйлчилгээг хийдэггүй. Дээрээс нь далайд гарцгүй. Тийм болохоор уул уурхайн компаниуд сэлбэг, хэрэгслээ засуулах болон шинээр авахын тулд хилийн чанадаас төмөр зам эсвэл автозамаар тээвэрлэдэг аж. Энэ нь тоног төхөөрөмжийн

засвар үйлчилгээ авахад хүндрэл учруулдаг талаар “Вагнер Ази Тоног Төхөөрөмж” компанийн Уул уурхайн газар хариуцсан захирал Б.Баттөр хэлсэн юм.

Өнгөрсөн оноос “Дархангеомаш” ХХК уул уурхайн тоног төхөөрөмж, сэлбэг үйлдвэрлэл, засварын чиглэлээр үйл ажиллагаа явуулж эхэлсэн байна. Тус компани 1994 оноос хойш үйл ажиллагаа явуулж иржээ. Одоогийн байдлаар 50-иад ажилтантай. Өнгөрсөн онд “катерпиллар”-ын машиныг сэргээн засварлах ажилд ханцуй шамлан орсон байна. “Катерпиллар” нь хөрсний самосвол, грейдер, бульдозёр зэрэг уул уурхайн томоохон машин механизмын брэнд. Сүүлийн үед газар доорх тоног төхөөрөмж нь Монголын томоохон уурхайд ашиглагдаж эхлээд байгаа.

“Дархангеомаш” компанийн инженер Э.Батбаяр “Уул уурхайн компанийн хувьд техникийн засвар үйлчилгээг цаг тухайд нь авч чадахгүйн улмаас олон тоног төхөөрөмжөө төмрийн хог дээр хаях нь цөөнгүй. Тиймээс бид уул уурхайн тоног төхөөрөмж сэргээн засварлах. Цаашлаад үйлдвэрлэх хүртэлх Америк технологийг оруулж ирэхээр ажиллаж байна. Сүүлийн 4-5 сарын хугацаанд уул уурхайн хүнд машин механизмын сэргээн засварлах ажлыг “Вагнер Ази” компанитай хамтран хийж эхэлсэн. Туршилт амжилттай дуусчихвал зарим тоног төхөөрөмжийг Монголдоо үйлдвэрлэх боломжтой. Мөн сэргээн засварлах ажлыг бүрэн хийнэ” гэв. Тус компани механик боловсруулалт, халуун төмөр цутгуур, засвар угсралт, гагнуур цех болон зураг тооцооны гэсэн хэд хэдэн инженерийн багтай. Инженер техникийн ажилчдын зураг тооцоогоор хийсэн даралтат савны оёор хэвлэх төхөөрөмж, хийн баллон үйлдвэрлэх цех, таван тоннын “ямаан” кран зэрэг төхөөрөмжүүд нь амжилттай ажиллаж байгаа аж. Хэдийгээр өнгөрсөн онд “Дархангеомаш” алдагдалтай ажилласан ч “катерпиллар”-ыг онилсон шинэ бизнес нь амжилттай болвол зардлаа ойрын хугацаанд нөхөх боломжтой гэнэ. Одоогоор Оюутолгойн захиалгаар ASME B16.47 Flange 150 A series, “ДДЦС”-ийн нүүрс хамагч гинж, “Бороо Гоулд”-ийн гидер моторын ротор үйлдвэрлэжээ. Мөн “Вагнер Ази” компанийн захиалгаар CAT брэндийн 16M “autograder” машины засварын ажлыг амжилттай хийсэн байна. ■



“Бороо Гоулд”-ийн гидер моторын ротор

ТОП-20

ҮНЭГҮЙДЭЛ ҮРГЭЛЖИЛСЭЭР


“Монголын цахилгаан холбоо” ХК үнэгүйдсээр байгаа юм биш биз. Энэ компани 2009 онд 2.9 тэрбум төгрөгийн ашигтай ажиллаж 440 саяыг ногдол ашиг болгон тарааж байсан. Дараа жил нь 1.8 тэрбум төгрөгийн ашигтай ажиллажээ. Гэтэл 2011 оноос огцом алдагдалд орж эхэлсэн байна. Дэлгэрэнгүйг графикаас харна уу.

Уг нь “Монголын цахилгаан холбоо” ХК гадаадын хөрөнгө оруулалттай, Монголын Засгийн газар арыг нь даадаг маш том компани. Тодруулбал, нийт хувьцааны 54.67 хувийг Монгол Улсын Засгийн газар эзэмшдэг. 40 хувь нь БНСУ-ын “Кореа Телеком” корпорацийнх. Үлдсэн 5,33 хувийг Монголын хөрөнгийн биржээр дамжуулан дотоод, гадаадын иргэд, байгууллага, холбоочид тус тус эзэмшдэг. Манай Засгийн газар болон “Кореа Телеком” компанийн хооронд байгуулсан багц гэрээний дагуу нийт 10 гаруй тусгай зөвшөөрлийг эзэмшдэг. “Олон улсын яриа”, “Суурин утас”, “Интернэт үйлчилгээ”, “Кабелийн телевиз” гэсэн үндсэн дөрвөн төрлийн үйлчилгээгээр Улаанбаатар, 21 аймаг, 159 суманд үйл ажиллагаа явуулдаг. Ингээд бодохоор тус компани цахилгаан холбооны талбарт хамгийн том нь яах аргагүй мөн. Тэр ч утгаараа компанийн хувьцаа Монголын хөрөнгийн биржийн “ТОП-20”-д багтдаг. Гэтэл ашгийн хувь хэмжээ жил ирэх бүр хасах үзүүлэлт рүү огцом уруудсаар байгаа. Тэрчлэн хувьцаа эзэмшэгчдийн ашиг буурахад ч мөн нөлөөлөөд байгаа аж. *(Дэлгэрэнгүйг графикаас харна уу)*

Компанийн үндсэн үйлчилгээний үзүүлэлтийг өмнөх оны мөн үетэй харьцуулбал олон улсын ярианы минут 12 хувиар буурсан байна. Түүнчлэн суурин утасны үйлчилгээ, интернэт үйлчилгээний цэгийн тоо, кабелийн телевизийн ▶




МЦХ ХК-ий нэгж хувьцаанд ногдох ашиг (EPS), 2005-2012



Үндсэн орлого, зардал, ашгийн байдал (2008-2013)



2013 оны бүтээгдэхүүн үйлчилгээний нийт орлогод эзлэх хувь



Альтманы индекс буюу дампууруулах эрсдэлийн индекс, (2007-2012)



▶ хэрэглэгчийн шинэ холболт гээд үндсэн үйлчилгээ нь бүгд буурсан үзүүлэлттэй. Ер нь үйл ажиллагааны цар хүрээ, хэрэглэгчийн тоо сүүлийн жилүүдэд буурсан нь орлогод шууд нөлөөлөөд байгаа аж. Монголд хувийн хэвшлийн

үүрэн телефоны дөрвөн ч оператор энэ салбарт ажилладаг. Тэд өвөрмөц онцлогтой үйлчилгээг хэрэглэгчиддээ санал болгодог. Тэр хэрээр хэрэглэгчид өрсөлдөгч компаниудын дэвшилтэт технологид суурилсан бүтээгдэхүүн үйлчилгээг сонгох болсон байна. Утасгүй интернэт, 3G технологи мөөд болж байгаа. Ийм үед “Монголын цахилгаан холбоо” ХК шинэ бүтээгдэхүүн, онцгой үйлчилгээ нэвтрүүлэхгүй л бол зах зээлд удаан оршин тогтноход хүндрэлтэй байж магадгүй.

Уг зах зээлийн шаардлагаар “Монголын цахилгаан холбоо” ХК удахгүй үүрэн холбооны дараагийн үе шат болох 4G сүлжээг Монголд нэвтрүүлэх гэж байгаа юм билээ. Монголын үүрэн холбооны операторуудаас 4G сүлжээг бие даагаад оруулж ирсэн компани одоогоор хараахан байхгүй. Хэрвээ компани уг сүлжээг оруулж ирээд, шинэ үйлчилгээ нэвтрүүлээд эхэлбэл, хувийн хэвшлийн үүрэн холбооны компаниудтай өрсөлдөх чадвар нь харьцангуй дээшилнэ. ■

ТЭРБУМТАН

КАЛЬКУТТЫН ТӨМӨР ЭР

Х.ХУЛАН

Лакшми Миттал бол дэлхийн хамгийн том гангийн үйлдвэр “ArcelorMittal”-ын тэргүүн билээ. Тэрбээр “Форбес” сэтгүүлийн “Дэлхийн хамгийн баян хүн”-ий 2012 оны жагсаалтад 21, Дэлхийн хамгийн нөлөө бүхий 70 хүний 47 дугаар байранд орсон байдаг. Нийт 16 тэрбум ам.долларын өв хөрөнгөтэй тэрбумтны амьдрал дандаа бартаагүй байсангүй. Түүний туулсан бизнесийн амьдралын замналаас хүргэж байна.

Лакшми Миттал нь Энэтхэгийн Ражастан мужийн Калькут хотод Мохан Миттал хэмээх бизнесмэний гэр бүлд 1950 оны зургадугаар сарын 15-нд төрсөн. Сонирхуулахад, тэрбээр марвар овогт хамаарагддаг. Пакистаны хил залгаа орших олон цөлүүдийн ойролцоо марвари овгийнхны суурин байдаг. Арилжаа наймаандаа гаргууд тэднийг Энэтхэгийн еврейчүүд гэдэг.



Шийдвэр гаргахдаа хурдан, арвич хямгач марварчууд голдуу гэр бүлийн бизнес эрхэлдэг. Тэд элит давхаргад тооцогддог аж.

Лакшмигийн эцэг 1971 онд

найзтайгаа хамтарч гангийн жижиг үйлдвэр худалдаж авчээ. Үйлдвэрээс олсон орлогоороо хүүгээ Калькуттын Сант Ксавиерын коллежийн бизнесийн ангид суралцуулсан байна. Лакшми ▶

сургуулиа 1969 онд бакалаврын зэрэгтэй дүүргэв. Энэ хооронд түүний аав нь санскритаар "Ispat" буюу төмөр гэсэн утгатай ган хайлуулах үйлдвэрийг нээж, удалгүй бизнес нь улам өргөжив. Энэ үеэс эхэлж Лакшми гэр бүлийн бизнест хөл тавьж, удалгүй 25 насандаа "Mittal Steel" хувийн компаниа үүсгэн байгуулснаар төмрийн хаант улсын хааны түүх нь эхэлсэн гэж үздэг.

Лакшмигийн бизнесийн дүрэм

Лакшми Миттал 1990-ээд оны эхээр голдуу төрийн өмчийн алдагдалтай төмрийн үйлдвэрүүдийг хямд үнээр худалдаж авч эхэлсэн. Тэрбээр тэдгээр үйлдвэрүүдээ өргөжүүлэн өөрийн хөрөнгөөр шинэчилдэг байжээ. Дампуурлын ирмэг дээр байсан олон аж ахуйн нэгжийг аварсан төдийгүй Лакшми тэдгээрээ олон улсын хамгийн ашигтай бизнес болгож, дүр төрхийг нь шинэ түвшинд гаргасан гэдэг. "Mittal Steel" компани өнөөдөр үйл ажиллагаагаа дэлхийн дөрвөн тивийн 14 оронд явуулж байна.

Лакшмигийн баримталдаг гол бизнесийн зарчим: тэрбээр зөвхөн дээд зэргийн сайн чанартай төмрийг хайлуулдаг. Түүнчлэн том бус жижиг үйлдвэрүүд босгохыг илүүд үздэг аж. Миттал Мексик, Канад, Ирланд, Казахстан, Өмнөд Африк, Хятадад хөрөнгө оруулсан. Германы Хамбург дахь төмрийн үйлдвэрийг 1995 онд авчээ.

Гучин жил- гангийн үйлдвэрлэл

Гучин жилийн хугацаанд төмрийн магнат, "ArcelorMittal"-ын гүйцэтгэх захирал Миттал Энэтхэгийн жижигхэн үйлдвэрийг дэлхийд нэгд жагсах ган үйлдвэрлэгч болгосон. Лакшми бизнесийн стратегиа өөрөө боловсруулдаг бөгөөд энэ тал дээр хамтрагч байдаггүй аж. Энэ нь мөн л түүний бизнесийн нэг онцлог юм. Одоогоос 10 жилийн өмнө түүний "Ispat" үйлдвэр америкийн алдартай "International Steel Group"-тэй нэгдэж дэлхийн хамгийн том гангийн үйлдвэр болсон түүхтэй. Үүний дараа жил нь буюу 2005 онд тус компани 28 тэрбум

ам.долларын бизнес эрхэлснээс 3.4 тэрбумын цэвэр ашигтай ажилласан байна.

Үйлдвэрийн хувьцааны 90 гаруй хувийг Митталын гэр бүл эзэмшдэг. Лакшми Миттал өөрийн хамгийн том өрсөлдөгч "Arcelor" компанийг сөгдүүлж, 2006-2007 онд гангийн үйлдвэртээ нэгтэж чадсан. Хоёр үйлдвэр нэгдэж "ArcelorMittal" хэмээх шинэ нэртэй болсон. Төмрийн хаант улсаа захиран зохицуулахын тулд тэргүүн баян Миттал жил бүр 350 мянган миль газар нисдэг.

Митталын бизнесийн нууц олон. Үүнээс хамгийн энгийн гурвыг ихэнх хэвлэлд бичсэн байдаг. Нэгдүгээрт, марвар овгийнхны амьдрах чадвар,

генетикийн онцлог давтагдашгүй. Хоёрдугаарт, бие даасан байдал, хөдөлмөрч чанар. Дэлхий ертөнц болон өөртөө харуулж чадах тэрхүү гайхамшигтай чанар мөн л марвар овгийн бэлэг гэж хэлж болно. Гуравдугаарт, Лакшмигийн оюунлаг чанар, зөн совин. Тэрбээр өөрөө энэ тухай ингэж хэлсэн байдаг: "Би ямар нэгэн давтагдашгүй зүйл хийж чадна гэдэгтээ ямагт итгэл дүүрэн байдаг байсан. Энэтхэгт миний боломж хомс гэдгийг ч мэдэрдэг байлаа. Гэхдээ гадаадад бизнес эрхэлдэг энэтхэг хүн асар том давуу талтай. Учир нь 300 гаруй хэл, бага үндэстэнтэй энэ улс оронд бэрхшээлийг туулж, зөвшилцөлд хүрч сурахаас өөр аргагүй юм." ■



*Би цаг хугацааг ...
мартдаг
... ач хүүхдүүдтэйгээ
цагийг өнгөрөөхөөр.*

*Миний бизнесийг
амжилтад хүргэх ажилтан
...
... шаргуу ажилладаг,
хөрвөх чадвартай, шинийг
санаачлагч байх хэрэгтэй.*

*Амьдралдаа засах зүйл
...
... гадаад хэл сурна.
Энэ бол гайхамшигтай
шинж чанар бөгөөд би
гурваас дөрвөн хэлээр ус
цас мэт ярьдаг хүмүүстэй
ажилладаг.*

*Мөнгө намайг ...
... өөрчлөөгүй. Би
урьдных шигээ л их
ажилладаг. Хийх зүйл
их байгаа тул улам их
ажиллах шаардлагатай.*

*Зөвлөгөөг ... авдаг
... гэр бүлээсээ..*

*Хүүхдүүддээ захидаг ...
... шаргуу ажиллах,
хичээл номондоо анхаар,
алдаа гаргахаас бүү ай.*

БОЛОВСРОЛ

ГАРЦАА ЗӨВ ТОДОРХОЙЛ

С.ЗАЯА

Монголын боловсролын тогтолцоо Улаанбаатар хотын замын хөдөлгөөнтэй яг адилхан. Энэ тодорхойлолтыг ХБНГУ-ын “Гёте” хүрээлэнгийн Бээжин дэх суурин төлөөлөгчийн газрын ажилтан, доктор Айке Чаке хэлжээ. Манай улс боловсролын тогтолцоогоо хэн нэгэн эрх мэдэлтний дураар өөрчилж, тэдний үзэл бодолд нийцүүлж хөтөлбөр баталдаг нь ийм шүүмжлэл байнга дагуулдаг. Энэ шүүмжлэлийг түр хойш тавиад манайх одоо ямар системээр явж буйг хөндье. Тухайн салбарт энэ онд улсын төсвөөс 1.2 их наяд төгрөг төсөвлөсний дөнгөж 4-5 хувийг сургалтад, үлдсэнийг нь урсгал зардалд зарцуулахаар болжээ. Гэхдээ энэ тоо өнгөрсөн оны боловсролын салбарын төсвөөс 5.7 хувиар нэмэгдсэн үзүүлэлт. Дэлхий нийтэд улсын төсвийнхөө 20-30 хувийг энэ салбарт зарцуулснаар хэвийн хэмжээнд хүрнэ гэсэн зөвлөмж байдаг аж. Харин манайх улсын төсвийнхөө 17 хувийг зориулж байна. Энэ тоог сонсоход их мөнгө мэт боловч яг юунд зориулж буйг нь авч үзэхээр учир дутагдалтай. Тухайлбал, Худалдан авалтын тухай хуулинд тендер зарлаж, сургуулиудад сургалтын хэрэглэгдэхүүн өгөх ёстой гэж заажээ. Гэтэл тендерээр очиж буй хэрэглэгдэхүүн чанартай эсэхийг хянахад бэрхшээл олон тулгардаг аж.

НҮБ-аас боловсролыг нэгдүгээрт гэсэн уриалга гаргаад байна. Дэлхийн нийтийн эдийн засагчдын судалгаагаар боловсролд оруулсан нэг ам.доллар ирээдүйд 15 болж өсөх ёстой гэж үздэг. Өөрөөр хэлбэл, хүнээ хөгжүүлснээр тухайн улс орон хөгжих учиртай. Харин манайх энэ үзэл баримтлалын хаана явна вэ.



Фотот Б.Бямба-Очир

МУИС-ийн Эдийн засгийн сургуулийн эрдэмтэн судлаачид боловсролд бусад салбараас хамгийн их мөнгө төсөвлөгддөг ч хангалттай биш байгааг судалгаагаар тогтоосон байна. Мөн сургуулиудад очиж байгаа төсвийн 70 хувь нь багш нарын цалин хөлс, 20 хувь нь халаалт, цахилгаан, ус зэрэг тогтмол зардал, 4-5 хувь нь томилотод зарцуулагдаж буй дүн гарчээ.

Монголд багшлах боловсон хүчний чадвар дутмаг байна. Чадвартай хүмүүс нь багш болохгүй байгаагийн гол шалтгаан нь цалин мөнгөтэй шууд холбоотой. Хүний амьдралын гол баталгаа цалин хөлс. Германд бага насны хүүхдүүдтэй ажиллах тусам тэдний цалин өндөр байдаг. Харин Монголд их, дээд сургуулийн багш нарынх нь цалин их байгаа нь хачирхалтай хэмээн ХБНГУ-аас Монголд ирж ажилласан

мэргэжилтнүүд гайхширчээ. Мөн тэд Монголын боловсролын тогтолцоо доороосоо явах биш, дээрээсээ бүх асуудлыг шийдвэрлэдэг. Тиймээс Монголын боловсролын байгууллагууд бие даан хөгжих ямар ч нөхцөл бүрдээгүй хараат байна. Энэ байдлаас гарсан цагт хүн бүр чөлөөтэй сэтгэж, улс орон, хувь хүн хөгжих болно гэдгийг ч хэлж.

Америкийн тогтолцоог Монголд нутагшуулах уу

Дэлхийн банкнаас боловсролын салбарт нэг хүүхдэд ногдох хувьсах зардал манайд ямар байгааг судалжээ. Хариу нь мэдээж хангалтгүй. Манайд өнөөдрийн байдлаар хувьсах зардалд тухайн багшийн цалин, хүүхдэд шаардлагатай бүхий л зардлыг оруулж тооцож буй аж. Сумын төвд байгаа ▶

▶ 150, аймгийн төвийн сургуулийн 600 хүүхдэд хичээл зааж буй багшийн цалин адилхан байдаг. Тиймээс багшийн ачааллыг нь харгалзан үзэж, нэг хүүхдэд ногдох хувьсах зардлаа хэрхэн тооцох. Боловсролын төлөвлөлт, хуваарилалтад өөрчлөлт оруулах зайлшгүй шаардлагатай байгааг яамны удирдлагууд онцолж байсан.

Манай ерөнхий боловсролын сургуулиуд Америкийн системээр явж байгаа гэнэ. Бага, дунд боловсролын төвшинд хүүхэд бүрийг өөрийн үзэл бодолтой, шийдвэр гаргах чадвартай, өөртөө итгэлтэй бүтээлч иргэн болгож төлөвшүүлэх зорилт тавьжээ. Түүнээс биш, хэдэн хичээл орох нь чухал бус гэж үзсэн байна. Мөн энэ жил боловсролын түвшин бүрт чанарын үнэлгээ хийхээр болж. Өөрөөр хэлбэл, ерөнхий боловсролын V, IX ангийн сурагчдын мэдлэг бус чадварыг тогтоох нь. Ингэснээр цаашид ямар арга барилаар ажиллах чиг хандлага тодорхой болно гэж үзжээ. Энэ талаар БШУЯ-ны Стратеги бодлого төлөвлөлтийн газрын дарга Б.Насанбаяр “Зөвхөн хичээлийн 40 минутад хүүхэд хөгжүүлэх юм шиг багш нар бодож ирсэн. Бид I-V ангийн сурагчдад одоо орж буй хичээлүүдийн агуулгыг нэгдмэл байлгахад анхаарч байна. Тухайлбал, монгол хэлний хичээл дээр уншсан эх нь байгалийн ухааны агуулгатай уялдах ёстой юм. Өдөрт тэдэнд 7-8 цагийн хичээл орж байна. Тухайн хүүхэд өдөрт төдий хэмжээний хичээлийн даалгавар хийнэ гэсэн үг. Ийм арга барилаар цаашид явбал хүүхдийн ачаалал нэмэгдэнэ. Тиймээс хичээлийнх нь цагийг багасгаж, үзсэн хичээлээ давтах цаг гаргаж өгөх юм. Улсын хэмжээнд 2014-2015 оны хичээлийн жилд уг ажлыг хэрэгжүүлнэ” гэв.

Боловсрол шинжлэх ухааны яам энэ жил бага, дунд боловсролын чанарын шинэчлэлд хөрөнгө мөнгө зарцуулах шаардлага тулгарчээ. Мөн багш нараа бэлтгэх, чадавхжуулах хэрэгтэй ч мэргэжил дээшлүүлэх зардал дутмаг байх жишээтэй. Үүнийг харгалзан үзэж, орон нутгийн хөгжлийн санд суулгасан хөрөнгөнөөс уг ажилд зарцуулж чадвал эргээд тухайн орон нутгийн хөгжлийн баталгаа болох учиртайг Б.Насанбаяр дарга яриандаа тодотгосон.

Дээд боловсролд шинэчлэл үгүйлэгдсээр

Гурав хүрэхгүй сая хүн амтай манай улс 100 гаруй их, дээд сургуультай. Тэдгээр нь чанартай, чанаргүй боловсон хүчин бэлтгэж буй нь дээд боловсрол гээчийг үнэгүйдүүлсэн. Үүний баталгаа нь 2009 онд улсын хэмжээнд 160 гаруй их, дээд сургууль байсныг аттестачилж, заримыг нь нэгтгэж 101 болгоод байна. Мөн өнгөрсөн жил салбарын яамнаас МУИС-ийн харьяа 16 сургуулийг нэгтгэсэн нь багагүй шүүмжлэл дагуулаад байгаа. Тус сургууль олон салбарт хуваагдсан нь сургалтын нэгдсэн бодлого алдагдахад хүргэсэн гэж судлаачид үзсэн байна. Энэ хэрээр санхүүгийн нэгдсэн төлөвлөлт ч муу байж. Судалгааны багийнхан бүтэн жил ажилласаны дүнд тус сургуульд бүтцийн өөрчлөлт хийхээс өөр аргагүй гэсэн дүгнэлтэд хүрчээ.

Мөнгөтэй хэд нь гадаадад боловсрол эзэмшиж, бэл бэнчин тааруу нь дотооддоо сургууль дүүргэх болсоор манайхан удаж байна. Сургалтын чанар, материаллаг бааз, орчин муу учраас Монголын их, дээд сургуулийн диплом олон улсад хүлээн зөвшөөрөгддөггүй. Үүнийг халж, сургалтын тогтолцоондоо дорвитой өөрчлөлт хийх цаг хэдийнэ болсон ч салбарын яам аар саархан зүйл хийснээ шинэчлэл хэмээн нэрлэсээр өнөөдөртэй золгосон. Дээд боловсролын салбарт зоригтой шинэчлэл хийж чадвал залуусын гадаадад сурч буй мөнгө Монголдоо


шингэнэ. Гэтэл салбарын яам сургуулийн тоонд анхаарахгүй гэнэ. Тэд энэ онд элсэлтийн ерөнхий шалгалтад 400-гаас дээш оноо авсан сурагчийг элсүүлэх шаардлага тавьж буй аж. Сургуулиудын тэнхмүүд хөтөлбөрөө өмчилчихсэн, цөөхөн багштай байгааг болиулж, гурван тэнхим нийлээд чанартай нэг хөтөлбөртэй болох ёстой гэж үзжээ.

2014-2015 оны хичээлийн жилээс их, дээд сургуулиуд сургалтын хөтөлбөрөө багцалж, оюутнууд хичээлээ сонгож судалдаг болох нь. Өнгөрсөн 20 гаруй жил нэг арга барилаар явж ирсэн нь боловсролын салбарын алдаа. Тухайлбал, зарим багш нар 10 жилийн өмнө уншиж байсан лекцээ шинэчлээгүй байх нь хэвийн үзэгдэл. Харин энэ жилээс бүх сургалтын хөтөлбөрийг онлайнд байршуулах юм байна. Энэ дагуу оюутнууд дадлага хийж, лабораторидоо ажилладаг болох аж.

БШУЯ-наас ерөнхий болон дээд боловсролын салбарт ийм бодлого барьж ажиллаж байна. Сургалтын хэрэглэгдэхүүн авах зардлыг сургууль, цэцэрлэг барих хөрөнгөнөөс тусад нь суулгаж өгөх. Хүнээ хөгжүүлэхийн тулд сургуулийн өмнөх болон бага боловсролын салбарт ажиллаж буй багш, ажилтнуудыг хөгжүүлэх, нийгмийн баталгааг нь өндөрсгөж байж манай улсын боловсролын тогтолцоо жинхэнэ утгаараа хөгжих гарц харагдаж байна. Үүнийг салбарын яамныхан ч дуу нэгтэй хүлээн зөвшөөрч буйг тэмдэглэх хэрэгтэй байх. ■

Боловсролын салбарын төсөв

сая төгрөг



ЭЛЧИН САЙД

Б.ДЭЛГЭРМАА: СИНГАПУРЫН САЙН ТУРШЛАГУУДЫГ НЭВТРҮҮЛМЭЭР БАЙНА

Д.БЭХЭЭ

Сингапур дахь Монголын Элчин сайд Б.Дэлгэрмаатай ярилцлаа. Эргэн тойрон усаар хүрээлэгдсэн жижиг газар нутагт таван сая хүн баян чинээлэг, тайван амьдарч байна. Байнгын зуны улиралтай энэ улсад жилдээ 14 сая жуулчин ирдэг статистик бий. Мөн Азийн бар болсон тус орны хөгжлийн нууц юунд байна вэ. Монголын Элчин тус улсад ажиллаж амьдарч буйн хувьд хөгжлийн нууцыг хэрхэн харж байна вэ. Сингапурын төв дэх тэнгэр баганадсан барилгын 24 дүгээр давхарт байрлах Монголын ЭСЯ-ны байранд бидний ярилцлага өрнөсөн юм.



-Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Сингапур улсад томоохон хэмжээний айлчлал хийсэн. Айлчлалын үр дүнг Элчин сайдын хувьд Та хэрхэн харж байна вэ?

-2001 онд хийсэн Ерөнхийлөгч Н.Багабандийн айлчиллаас хойш 12 жилийн дараа болсон өндөр ач холбогдолтой айлчлал юм. Хоёр орны төрийн дээд хэмжээний айлчлалын давтамж ойр байх тусам харилцаа сайжирч, үр дүн гардаг. Сингапур улстай 1970 онд дипломат харилцаа тогтоосон ч Сингапурын талаас манай улсад төрийн өндөр түвшний айлчлал

хийгээгүй байгаа. Ерөнхийлөгч Ц.Элбэгдорж Сингапурт айлчлахаасаа өмнө ухаалаг төрийн асуудлыг хөндөж, бодлогоо тодорхойлж ирсэн нь чухал ач холбогдолтой байлаа. Сингапур нь ухаалаг төрийн системээр тэргүүлэгч бодлоготой, үлгэр жишээ төдийгүй бүс нутагтаа, АСЕАН-ы орон дундаа зуучлагчийн үүрэг гүйцэтгэдэг, мэдээлэл технологи, эдийн засаг, батлан хамгаалах, банк санхүүгийн төв болсон орон. Монголтой адил төстэй зүйлүүд бий. Том улсуудын дунд оршсон жижиг газар нутагтай учраас үндэсний аюулгүй байдал,

эдийн засгийн хөгжилд гарц олсон улс. Бидний хувьд сурах, үлгэр жишээ авах их зүйлтэй орон юм.

Монголын хөрөнгө оруулалтын орчин 2012 оноос буурч, нэр хүнд унасан энэ үед Ерөнхийлөгч айлчилснаар олон асуудлыг хариуг сингапурчуудад өгч чадсан.

Бизнесийн форумд хэлсэн үгээрээ Ерөнхийлөгч маань хөрөнгө оруулагчдын эргэлзээг тайлсан гэж үзэж байна. Тус айлчлалын зорилго Сингапурт Монголын хөрөнгө оруулалтын орчны талаар сурталчлан таниулахад чиглэж байсан. Дүгнээд хэлбэл, Монголд хөрөнгө оруулахаас бүү ай. Таны оруулсан хөрөнгө оруулалт хэд дахин өснө. Монгол асар их баялагтай. Төр нь тогтвортой, хүчтэй, амласнаа биелүүлдэг. Хөрөнгө оруулалтын баталгаа нь Монгол Улсын төр өөрөө гэсэн утгатай эерэг мэссэжийг өгсөнд нь Ерөнхийлөгч Ц.Элбэгдоржийн айлчлалын гол үр дүн юм. Ийм том мэдэгдэл хийх болсон шалтгаан нь Сингапур хоёр том гүрний дунд оршдог улс. Тэгвэл Монгол их гүрнүүдийн дундах далайд гарцгүй орон. Манай улс бүс нутгийн интеграчлалын бодлогод орж чадахгүй байна. Бүс нутгийн худалдааны бодлогод орж байж л уул уурхайн бүтээгдэхүүнийг сайн үнээр борлуулж чадна. Орос, Хятадын хамаарлыг багасгах болно. Үүний тулд төр нь ухаалаг байх ёстой.

-Айлчлалын хүрээнд зарим нэг бодитой асуудлыг шийдвэрлэсэн. Тухайлбал, Сингапур хороолол, шууд нислэг гэх мэт?

-Сингапур нь тав таван жилийн төлөвлөгөөтэйгээр улсаа хөгжүүлж ирсэн онцлогтой. 60-аад оноос бүх иргэнээ орон сууцжуулах хөтөлбөрийг ▶

► амжилттай хэрэгжүүлсэн. Орон сууцны хөгжлийн зөвлөл гэж байдаг. Орон сууцжуулах хөтөлбөр нь хэдэн байшин барилга босгох тухай ярьдаггүй. Бүхэл бүтэн хот төлөвлөлтийн асуудлыг цогцоор нь тусгаж, хэрэгжүүлснээр иргэдийн тайван, тохьтой ажиллаж амьдрах орчныг бий болгосон хорооллууд босч ирдэг. Энэ чиглэлээр арвин туршлага хуримтлуулсан улс. Тухайлбал, Сингапураас Дубай хотын ерөнхий төлөвлөгөөг гаргаснаар өнөөдөр тус хотын метро, машины түгжрэлийн асуудлыг цэгцэлсэн. Тэгэхээр Сингапур хорооллыг Улаанбаатарт барихаар тохирсон нь онцлогтой. Хэдийгээр халуун бүсийн улс ч гэлээ байшин барилгыг дан барилга гэж харахгүйгээр цогц дэд бүтэцтэйгээр шийдэж байгаа нь манай төрийн түшээдэд нэгийг бодогдуулсан болов уу.

Улаанбаатар хотын захирагч Э.Бат-Үүл болон албаны бусад төлөөлөл орон сууцны хөтөлбөртэй уялдсан хот төлөвлөлт, хог хаягдал, метро болон ус цэвэршүүлэх станцын үйл ажиллагаатай танилцсан. Сингапур нь дэлхий дээрх усны нөөцгүй ганц орон. Малайзаас усаар 100 хувь хамааралтай бөгөөд энэхүү хамаарлаа өнөөдөр 80 хувьтай арилгаж чадсан. Борооны усны нөөц бий болгох, саарал усыг ашиглах зэрэг бодлогыг хэрэгжүүлэхээс гадна далайн усыг цэвэршүүлэх станцыг ашиглалтад орууллаа. Далайн шорвог усыг цэвэршүүлж, ундны усны хэрэглээнд хүртэл ашиглана гэдэг бол технологийн, шийдлийн гайхамшиг юм. Хөгжлийн ийм гарц, шийдлүүд манай албаны хүмүүс сонирхлоо. Уул уурхай ашиглалтад орж байгаатай холбоотой усны хэрэгцээ манайд ихэсч байна. Усыг ариг гамтай хэрэглэх, хэрэглэсэн усаа эргүүлж ашиглах, усны нөөцийг бий болгох, саарал усны туршлагыг нэвтрүүлэхэд анхаарал хандуулж, бодлогоо чиглүүлэхэд энэ орны арвин туршлага хэрэгтэй.

-Шууд нислэгийн талаар юу хэлэх вэ?

-Миний бие 2012 оны хоёрдугаар сард итгэмжлэх жуух бичгээ барьснаас хойш хоёр орны хоорондох шууд нислэгийн асуудлыг холбогдох хүмүүсийн түвшинд багагүй ярьж ирсэн. Энэ асуудал удахгүй шийдэгдэх байх аа. Сингапурт манай иргэд аялал жуулчлал, боловсрол, эрүүл мэндийн чиглэлээр их ирж байна. Мөн шууд

нислэг нь Бээжин, Хонгконгоор дамжин Монголд очиж буй хүмүүсийн цаг завьг хэмнэнэ. Дэлхийн хоёр дахь том онгоцны буудал шүү дээ. Монголын хувьд аялал жуулчлалын том чиглэл. Сингапурчуудыг дэлхийн хоёр дахь том генерацн гэж хэлье. Хэтэвч зузаан иргэдтэй баян орон. Сингапурт жилдээ 14 сая жуулчид ирж байна. Яг үнэндээ Сингапурт үзэх үзвэр ховор шүү дээ. Гэтэл яагаад энэ улс руу хүмүүсийн урсгал хошуураад байна вэ гэдэг нь сонирхол татна. Долоо хоног тутам олон улсын томоохон үзэсгэлэн яармаг болж байна. Австралийн компаниудын төлөөлөгчид Сингапурт ирж хурал зохион байгуулж байна. Энд томоохон хурал хийх хүчин чадал бүхий зочид буудал, хурлын танхимуудтай. Үйлчилгээний чанар, соёл өндөр. Тэгвэл манайд том хэмжээний олон улсын хурал семинар зохион байгуулах хүчин чадалтай зочид буудал, танхимууд байна уу. Үйлчилгээ, хоолны чанар ямар билээ. Ялангуяа үйлчилгээний чанарт шинэчлэл хийх хэрэгтэй гэж бодож байна. Нэг үеэ бодвол уул уурхайтай холбоотой хурлууд манайд хийх болсон шүү дээ. Үйлчилгээ дагаж орлого орж ирнэ гэдэг талаас анхаарч ажиллах шаардлагатай байна.

-Хэчнээн монгол ажиллаж амьдарч байна вэ, энд?

-170-180 монгол амьдарч байна. Ихэнхдээ хүүхдүүд нь бага сургуулиудад сурдаг учраас тэднийгээ дагаад эцэг эх нь амьдарч байна. Сингапурын боловсролын чанар маш сайн. Дээр нь зөвхөн англи бус хятад хэл сурах боломжтой. Сургалтын систем нь Британийн системтэй холбогддог учраас Лондон, Австралийн их, дээд сургуульд сурах түвшний дипломтой төгсдөг. Дээр нь сургалтын төлбөр нь харьцангуй хямд. Мөн эмнэлгийн үйлчилгээ авах зорилготой манай иргэдийн хөл тасардаггүй. Сингапураас элэг шилжүүлэх нарийн мэргэжлийн баг Монголд очиж ажиллаж байгаа. Түүнчлэн шүд, гоо сайхан, бөөр гэх мэт өвчний чиглэлээр хамтарсан хөрөнгө оруулалтаар эмнэлэг байгуулах асуудлууд яригдаж байна.

-Сингапурын хөгжлийн нууцын тухай олонтаа ярьдаг. Таны хувьд юу гэж харж байна вэ?

-Энэ орон 1965 онд тусгаар тогтнолоо олсноос хойш гурван том

зорилт тавьсан. **Нэгдүгээрт**, бүх нийтээрээ англи хэлтэй байх ёстой. Хүн төрөлхтний хөгжлөөс хоцрохгүй, суралцаж, тэргүүлэх эгнээнд явахын тулд англи хэлээр дамжуулан боловсролд маш их анхаарвал хөгжилд хүрч чадна гэж тодорхойлсон. Энэ нь мэдээж өнөөдрийн хөгжилд хүргэхэд гол үүрэг гүйцэтгэсэн. **Хоёрдугаарт**, орон сууцжуулах хөтөлбөрийг шат дараатай хэрэгжүүлсэн. Иргэн сайхан байранд, сэтгэл хангалуун амьдарвал тухайн хүний хөдөлмөрийн бүтээмж сайжирна гэж үзсэн. **Гуравдугаарт**, авлигаас ангид байх ёстой. Үүний тулд эрх зүйн орчноо сайжруулж, хуулиа ягштал мөрдсөн. Гудамжинд бохь зажилвал 1000 доллар, түмпэнтэй усаа гадаа хонуулж болохгүй, шумуул үржинэ гэсэн байхад зөрчвөл 1000 доллар, нохойгоо шөнө хуцуулж болохгүй, Аниргүйн тухай хуулиар шөнө дөлөөр нохойгоо хуцуулсан айлд торгууль ногдуулна. Ингэхийн тулд айл нохойгоо шөнө хуцуулдаггүй сургалтад хамруулна, бүр хуцаад байвал нохойных нь улаан хоолойд хагалгаа хийж, хуцдаггүй болгоно. Ийм хатуу чанга эрх зүйн орчноор төгс төгөлдөр төрийг бий болгож чаджээ.

Авлигаас ангид байхын тулд эхлээд шүүгч, төрийн албан хаагчдаа хангалттай цалин өгсөн. Бизнесийн орчныг хүнд сурталгүй байлгах талд ихэд анхаарч, үүд хаалгаа хөрөнгө оруулагчдад цэлийтэл нээсэн. Манайд хөрөнгө оруулаач, хөрөнгө оруулахад ямар ч асуудалгүй эрх зүйн орчныг бүрдүүлсэн зэргээр хөрөнгө оруулагчдыг тойлж, гүйсний дүнд хэдэн мянган компани, аж ахуйн нэгж, олон улсын 110 банк санхүүгийн байгууллага ажиллаж байна, Сингапурт. Компанийг 30 минутад л бүртгэж, нэг цонхны үйлчилгээг жинхэнэ утгаар нь хэрэгжүүлсэн улс. Энэ нь Сингапурын төр, засаг ухаалаг, тунгалаг, хариуцлагатай ажилласны үр дүн юм. Мөн тус орны баялаг нь хүн. Хүндээ бүх зүйлээ зориулж, хөрөнгө оруулж боловсрол, эрүүл мэндэд нь анхаарсан бодлого түлхүү явуулж байна. Өнөөдрийн өрсөлдөөнт нийгэмд сингапур иргэн яаж баян цатгалан, тайван, стрессгүй амьдрах вэ гэдэгт л төрийн бодлого нь чиглэдэг учраас улс орон нь хурдацтай хөгжиж, иргэд нь илүү их хөдөлмөрлөх сэтгэлгээтэй болж, тайван сайхан амьдарч байна.

-Та Сингапурын төрийг ухаалаг, ►

► **үлгэр жишээ төрийн системтэй гэсэн. Монголын төрийн удирдлага ухаалаг төр рүү шилжих тухай ярьж тодорхой ажлыг эхлүүлээд байна. Сингапурын ухаалаг төрийн бодлогын туршлагаас хуваалцана уу?**

-Мөнгө гаргахгүйгээр ухаалаг төртэй болох хэдхэн жишээг хэлье. Юуны түүвэнд манай төрийн байгууллагуудын ажлын арга барил, менежментийг өөрчлөх хэрэгтэй. Энд олон байгууллагаар орж, ажил хөөцөлдөх, мөн ажил хэргийн холбоо харилцаатай ажиллаад ирэхээр хөнгөн шуурхай, ямар ч хүнд сурталгүй, ажил хэрэгч систем үйлчилж буйг улам бүр мэдэрдэг. Гэтэл Монголын төрийн байгууллага, агентлагууд руу мэйл бичихээр ямар ч хариу өгөхгүй, усанд хаясан чулуу шиг алга болчихдог. Миний хувьд Ерөнхийлөгчийн санаачилгыг бүрэн дэмжиж, Сингапурын хэд хэдэн туршлагыг Монголд нэвтрүүлмээр байна. Үүнд татвар төлөгчдийн мөнгийг зарцуулах шаардлагагүй.

Хамгийн эхний асуудал бол цагийн юмыг цагт нь хийж сурах. Манайд төрийн яамд нь хүнд сурталтай, тухайн асуудлыг шийдэх гэж хэдэн сар болдог, сайдын зөвлөлийн хурлаар оруулна гээд л цаг аваад байх. Сайдынх нь цаг зав гардаггүй ийм л дүр зураг байдаг шүү дээ. Энд бүх зүйл, цаг минутаар хэмжигдэж, бүх зүйлийн зорилго тодорхой байдаг. Сингапурт нэг яамны сайдтай уулзах цаг авахын тулд ямар асуудлаар хэдий хэр хугацаанд зарцуулах, ямар үр дүнд хүрэхээ тов тодорхой бичих ёстой. Монголоос ирж буй хүмүүс ажлын зорилгоо зөв тодорхойлоход суралцмаар байна.

Өөр нэг асуудал нь төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, хамтын ажиллагааг бий болгох. Ялангуяа гадаад улс орнуудад суугаа ЭСЯ-тайгаа уялдаа холбоотой ажилламаар байна. Яагаад Чингис хаан биднийг Элч гэж нэрлэсэн юм. Элч бол тагнуулч. Орчин үеийн тагнуулч Элч нар тухайн орныхоо хөгжлийн талаарх мэдээлэл цуглуулж төв рүүгээ явуулах үүрэгтэй. Гадаад хэргийн яам тэрхүү явуулсан мэдээлэл дээр анализ хийгээд дамжуулагчийн үүрэг гүйцэтгэх ёстой. Энэ мэдээллийг Эдийн засгийн яам, тэрийг нь Эрчим хүчний яам руу явуул. Монголдоо хэрэгжүүлэх боломжтой мэдээлэл нь энэ байна. Улс орнууд хөрөнгө



Монгол Улсын Элчин сайд Б.Дэлгэрмаа Сингапур улсын Ерөнхийлөгч Тони Тан Кенг-д итгэмжлэгдсэн жуух бичгээ өргөн барьж буй нь. 2012.2.23

орчуулалтыг ямар салбарт хийж үр дүнд хүрсэн байна, бидний явуулж буй бодлого зөв эсэх дээр Элчингүүдээс авсан мэдээлэл дээрээ тулгуурлан ажиллаж, шийдвэр гаргахдаа ашиглах. Тэгээд ГХЯ дипломат бодлогоороо эргээд салбарын яамдаас саналаа цуглуулж аваад ЭСЯ руугаа явуулж, энэ асуудлуудыг ажил хэрэг болгоход анхаарч ажилла хэмээн чиглүүлж ажиллах ёстой. Гэтэл өнөөдөр ГХЯ мэдээлэл хүлээн авлаа гээд л таг чиг болдог.

Төр нь ухаалаг байвал иргэд нь сайхан амьдарна. Монгол хүн боловсрол руу үеийн үед тэмүүлж ирсэн. Өндөр боловсрол, соёл эзэмшсэн залуусаа алсыг харсан төрийн бодлогоор зөв байршуулж, зөв ашиглаж, ажилуулж чадахгүй, олон улсын байгууллага, хувийн хэвшил, гаднын компаниудад алдаад байна. Энэ нь төрийн ухаалаг бус бодлоготой холбоотой.

-Та төрийн албанд олон жил ажилласан хүн. Өнөөдөөр хилийн чанадаас харвал манай засгийн бодлого, үйл ажиллагаа хэр байна вэ?

-Маш товчхон хэлэхэд, би төрийн үйл ажиллагааг өөрийн туршлага, алдаа онооноосоо дүгнэн хараад алив зүйлд шинжлэх ухаанч байр сууринаас хандах хандлага дутагдаад байна л гэж үздэг. Тухайн нөхцөл байдлыг тодорхой хэмжээгээр судалчихсан судалгаа дээр үндэслэн шийдвэр гаргадаг л болмоор байна. Түүнээс сэтгэлийн хөдөлгөөн, нам, фракцын байр сууринаас, хувь улстөрчийн үүднээс хандаж асуудлыг шийдэх бол манай төрд ужгирсан өвчин. Сингапурт

өнөөдөр судалгааны томоохон think tank байгууллага олон бий. Улс төрийн өндөрлөгт ажиллаж байсан улстөрчид нь тэдгээр хүрээлэнгийнхээ захирлаар нь очдог. Тухайлбал, Зүүн өмнөд Азийн судалгааны хүрээлэнгээс долоо хоног бүр семинар явуулдаг. Тухайн орны төлөөлөгч, тухайн сэдвээр судалгаа хийсэн шинжээчийн илтгэл тавигдана. Эдгээр илтгэл, бодлогын суурь болсон судалгааг төрийн байгууллагууддаа явуулдаг. Яам нь судалгааг үндэслэж бодлого шийдвэрээ тодорхойлох замаар төрийн ажил явж байна. Түүнээс манай яамд шиг өдөр тутмын ажилд дарагдсан, байнгын хуралдсан байдалтайгаар ажил явахгүй ээ. Монголын яамд руу утасдахаар хуралдаж байна л гэх юм. Ерөнхийлөгчийн санаачилгыг илүү судалгаан дээр тулгуурласан ухаалаг төр байгуулах гэж ойлгож байгаа. Судалгаа бол амьдрал. Хоёрдугаарт, асуудлыг цогцоор нь авч үзэж, зөв шийдэх. Бид өнөөдөр алив зүйлийг өм цөм, энд тэндээс нь авч шийдээд байна. Сингапурчууд жижигхэн зүйлд ч их нямбай хандаж, ул суурьтай шийддэг улс.

-Энэ жижиг газар нутаг дээр таван сая хүн амьдарч, тэнгэр баганадсан барилга байшин, хорооллууд, олон арван машин тэрэг сүлжилдэн байгаа мөртлөө замын түгжрэл үүсэхгүй юм. Ямар бодлого, дүрэм хэрэгжүүлсэн юм бол?

-Замаа нэг урсгалтай л болгосон.

-Сингапурын хөрөнгө оруулагчид манай аль салбарыг түлхүү сонирхож байна вэ?

-Ерөнхийлөгчийн айлчлалын ►

дараа манай орныг сонирхсон хөрөнгө оруулагчид нэмэгдсэн. Одоогоор “Темасек холдинг” Оюутолгойд хөрөнгө оруулалт хийсэн байгаа. Дэлхийд нэр хүндтэй том компани. Энэхүү хөрөнгө оруулалтын үр дүн хэр байхаас дараагийн хөрөнгө оруулалтуудын урсгал шийдэгдэнэ. Сингапурчууд “Танайд газар байна. Манайд хөрөнгө мөнгө байна, мөн бэлтгэгдсэн боловсон хүчин байна, хамтраад ажиллаж гэдэг. Сингапур хороолол барих, хот төлөвлөлт, эмнэлгийн салбар зэрэг сонирхож буй салбар бий. Гэхдээ Сингапурын хөрөнгө оруулалтыг манай төрөөс хамгаалж чадах эсэхээс хамааран хамтарч ажиллах саналууд гарч ирж байгаа.

-Төрийн албаныхныг сургалтад хамруулах талаар ямар арга хэмжээ авч ажиллаж байна вэ?

-Сингапурын техник хамтын ажиллагааны хүрээнд төрийн албан хаагчдыг Сингапурт сургаж байна. Энэхүү сургалтад хамрагдсанаар төрийн ажлын албаны уялдаа холбоо, цагийн менежмент, төрийн албан хаагчийн ёс зүйд суралцаж, мэдлэг мэдээлэл их олж авдаг гэж ойлгодог. Усны менежмент, иргэний агаар, банк санхүүгийн чиглэлээр сурч байна. Төрийн албаны анхан, дунд шатны хүмүүсийг сургаа гэхээр хэлний бэрхшээлтэй тулгараад байгаа. Сингапурт нэг, хоёр хүнийг биш, нэг орноос 5-8 хүнийг багаар нь авчирч сургахыг зорьдог. Ингэснээр багаар ажиллах чадварыг бий болгож, онолыг практиктай хослуулж, шийдлийг олоход, эндхийн тухайн чиглэлийн байгууллагуудтай очиж танилцуулж, туршлага солилцох, холбоо харилцаа тогтоох замаар сүлжээ үүсгэх нөхцөлийг бүрдүүлдэг онцлогтой сургалт. Тэгэхээр манай төрийн албаныхан хазгай муруй ч мэргэжлийн чиглэлээрээ ярьдаг болоход анхаараасай. Англи хэлтэй бол хаана л бол хаана сурч, мэргэжил боловсролоо дээшлүүлэх боломжтой.

-Удахгүй Цагаан сарын баяр болно. Сингапур дахь Монголын ЭСЯ Цагаан сараа хэрхэн тэмдэглэдэг вэ?

-Манай ЭСЯ 2008 онд байгуулагдсанаас хойш иргэдээ хүлээж аваагүй юм билээ. 2012 онд ирээд би Цагаан сараар анх удаа монголчуудаа хүлээн аваад даруухан тэмдэглэсэн л дээ. Тавган идээ засаад, цай, кофегоор дайж, хүүхэд, ахмадууддаа гарын бэлэг өгсөн. Өнгөрсөн оны Цагаан сарыг сайхан тэмдэглэе, гэхдээ цөөхөн хүн ирнэгээд бууз, зууш хийж, сүүтэй цайгаа чанаад байтал 150-иад хүн ирсэн. +30 хэмд уламжлалт баяраа тэмдэглэж, буузаа идээд, сүүтэй цайгаа уугаад л, Элчин сайдтайгаа золгохоор дугаарлан зогсож буй иргэдээ харахад сайхан санагдсан шүү. Ингээд монголчууддаа Сар шинийн баярын мэндийг дэвшүүлж, аз жаргал, эрүүл энхийг хүсэхийг зэрэгцээ Цагаан сарын баяраа өргөн дэлгэр сайхан тэмдэглэхийг хүсэн ерөөе. ■

ХӨРШ

СОЧИГИЙН ӨВЛИЙН ОЛИМПИЙН ТӨСӨВ

Орчуулсан Р.ГАНТУЛГА

ОХУ-ын Сочи хотноо энэ сарын 7-нд эхлэх өвлийн олимпийн цогцолбор түүхэнд байгаагүй хамгийн их зардлаар босч байгаа билээ. Анх 12 тэрбум ам.долларын өртөгтэй хэмээн тооцож байв. Гэвч одоогийн байдлаар 50 тэрбум ам.долларт хүрээд байгаа аж. Энэ нь 2004 онд болсон Афины олимпийн зардал болох 15 тэрбум ам.доллараас хол давсан тоо. Мөн Мьянмар улсын жилийн төсөвтэй тэнцэхүйц хэмжээний асар их мөнгө юм. Зардлаа нөхөх боломжгүй хэмээн эдийн засагчид үзэж байна.

Канадын Western Ontario их сургуулийн Олимп судлалын олон улсын төвийн захирал Роберт Барни “Олимпийн ихэнх тоглолт Засгийн газрын сангууд болон татвар төлөгчдөөс татаас авч байгаагүй. Хэрэв ингэсэн бол нэг ч тоглолт зардлаа нөхөж чадахгүй байх байсан” гэжээ.

Олимп зохион байгуулах эрх олж авахын тулд орнууд итгэмээргүй том амлалт өгч, ихээхэн хүчин чармайлт гаргадаг байна. Энэ нь олимпийн эрхийг “лоббидох” сонирхолтой улс төрчид байдагтай холбоотой. Мөн тоглолтын дараа үүсэх санхүүгийн хүндрэл, замбараагүй байдал зэргийг цэвэрлэдэг улстөрчид ч байдаг. Эдгээр нь хоорондоо ихээхэн ялгаатай юм байна.

Энэ талаар АНУ-ын San Diego их сургуулийн Спортын бизнесийн удирдлагын магистрын хөтөлбөрийн захирал Скотт Минто “Олимпийн тоглолтыг зохион байгуулах, сурталчилгаа явуулах эрхийг авах нь ялалт байгуулсан мэт тун ч сайхан санагддаг зүйл. Хүн бүр л эх оронч үзэлтэй болж, тоглолтыг зохион байгуулж байгаадаа өөрсдөөрөө бахархдаг. Гол асуудал нь үүнээс хойшхи наймаас арван жилийн дараа гарч ирэх үр дагаврыг тэд тооцоогүйд оршино. Тухайн тоглолтыг зохион байгуулахад гол дүрд тоглож байсан улстөрчид хэдэн жилийн дараа арилад өгсөн байдаг. Үүний дүнд зардлаа нөхөх боломжгүй, ашиглагдахгүй хоосон хоцорсон хэдэн том байгууламж л үлддэг” гэжээ.

Сочигийн хувьд хуучны амралтын газар байв. Оросын алслагдсан хэсэг болох дулаан орны уур амьсгалтай Хар тэнгисийн эрэгт, Гүржийн хилтэй ойролцоо байрладаг аж.

Хууль бус мөнгө ба аюулгүй байдал

Сочигийн өвлийн олимпийн тоглолтын зардал огцом нэмэгдсэн шалтгааныг дурдвал: орон нутгийн барилгын компанид авлига өгсөн. Террорист халдлагаас урьдчилан сэргийлэхийн тулд авсан аюулгүй байдлын хатуу арга хэмжээ. Ойр хавийн ууланд шинээр барьсан өвлийн байшин, барилга зэрэг багтаж буй. ОХУ-ын албаны хүмүүсийн хэлж буйгаар олимпийн тоглолтын дараа Сочи 343,000 оршин суугчтай, өвлийн спортын цогцолбор хот болгохоор төлөвлөсөн аж. ▶

▶ “Олимпийг өмнө зохион байгуулж байсан бусад хотын адил бүс нутгийн аялал жуулчлалыг нэмэгдүүлж, Оросын соёл, хөгжлийг дэлхий дахинд танилцуулахыг эрмэлзэж буй нь мэдээж” хэмээн Webster их сургуулийн эдийн засгийн профессор Пат Риш хэлсэн байна.

Гэхдээ Сочи нь ирээдүйд жуулчдын очих дуртай газар болох эсэх нь эргэлзээтэй гэдгийг Denver их сургуулийн эдийн засгийн профессор Артур Флейшер хэлжээ. Тэрбээр “Олимпийн тоглолтын дараа хүмүүс Сочид суурьших эсэх нь тодорхойгүй. Бараг л үгүй болов уу гэсэн юм.

Грекийн Афин хотын төв цэнгэлдэх хүрээлэн болон бусад байгууламж өдгөө маш тааруухан төрхтэй байгаа аж. Ашиглалт ч байхгүй, олон зуун сая ам.долларын үргүй зардал болон хувирч буйг эдийн засагчид хэлж байна.

ОХУ-ын улс төрийн сөрөг хүчний тэргүүн нэгэн мэдэгдэл хийжээ. Үүнд Сочид Олимпийн хотхон барьж байгуулах зардлын хувьд нэг суудалд 19,000 ам.доллар ногдох болно. Гэтэл өмнөх олимпийн тоглолтуудын дундаж өртөг нь 6,000 ам.доллар байсан гэжээ. Нийт хөрөнгийн 90 хувийг нь хувийн хэвшлээс биш, харин Засгийн газраас гаргасан талаар мөн дурджээ.

“Оросын Засгийн газар Сочигийн олимпийн цогцолборыг барьж байгуулахад гайхмаар үрэлгэн хандаж байна. Гэхдээ энэ нь цаашид гаднын жуулчдыг татах шинэ цанын бааз, амралтын газрыг барьж чадаж байгаа болов уу” хэмээн Loyola Marymount их сургуулийн харилцаа, холбоо судлалын профессор Кристофер Финлей хэлсэн байна.

Дээрх профессор, эдийн засагчдын хэлснээр олимпийн тоглолтыг зохион байгуулахад гаргасан зардлаа нөхөх нь боломжгүй мэт. Гэхдээ энэ нь тухайн хотын онцлогоос шалтгаалах аж. Тухайлбал, олимпийн цогцолборт зориулсан хурдны галт тэрэг, дэд бүтцийн төслүүд нь эргээд орон нутгийн барилгачдад ихээхэн дэмжлэг үзүүлдэг. Үүний зэрэгцээ хүмүүст тав тухтай орчинд амьдрах боломжийг бүрдүүлдэг байна.

Олимпийн эрхийг авахаар өрсөлдсөн болон авсан хотуудын гадаад худалдаа 30 хувиар нэмэгддэг болохыг нэгэн судалгаа харуулжээ. Энэ нь тэдгээр хот олимпийн эрхийн

төлөө өрсөлдөхдөө дэлхийн орнуудтай нээлттэй бизнес хэрхэн хийдгээ харуулахыг ихээхэн эрмэлздэгтэй нь холбоотой юм байна. Мөн тоглолт зохион байгуулж буй орны тамирчдын медалийн тоо 54 хувиар өсдөг болохыг уг судалгаа харуулжээ.

▶ санхүүжүүлэх таван сая ам.долларын бонд гаргах саналыг дэмжээгүй байна. Олон улсын олимпийн хорооноос төрөөс мөнгө гаргахыг хүлээн зөвшөөрөөгүй аж. Улмаар тоглолтыг Австрийн Инсбрук хот руу шилжүүлж байсан түүхтэй.



Хот болгон олимпийн эрхийн төлөө үхэн хатан тэмцдэггүй аж. Тухайлбал, Денвер хот 1976 оны өвлийн олимпийн тоглолтыг зохион байгуулах эрхээр шагнуулж байв. Гэвч 1972 онд Колорадогийн иргэд тухайн тоглолтыг

Артур Флейшер “Санал, зөрөлдөөнтэй асуудал нь хүмүүс тоглолтыг үзэхээр очихдоо мөнгө төлөх. Гэвч тэдний зарлагадсан мөнгө нь өөр зүйлд зориулагддаг. Олимпийн тоглолт болж буй хотынхон тоглолтыг ▶

► амьдаар үзэхгүй байх явдал элбэг. Учир нь зардал их гарах. Гаднаас ирсэн жуулчид хаа сайгүй хөлхөн байдагтай холбоотой” гэжээ.

Канадын Монреаль хотод 1976 онд болсон зуны олимпын тоглолтын зардлыг бүрэн нөхөхийн тулд 30 жил зарцуулсан гэдэг.

Зардлыг бууруулах нь

Олимпын тоглолтыг зохион байгуулах хотыг сонгохдоо материаллаг бааз сайтай, хамгийн тохиромжтой, зардлыг аль болох бууруулах боломжтой хотыг сонгох нь зүйтэй гэж зарим эдийн засагч үздэг. Гэхдээ нөгөө талаас, энэ шийдэл нь хэдэн хөгжилтэй хотод олимп зохиогддог л болгоно. Тэгвэл хөгжиж буй орнуудын олимпын тоглолт зохион байгуулах эрхийг хязгаарласан хэрэг болно гэж үзэх ч хүн байна.

Дээрхээс өөр хувилбар буюу барилгын өвөрмөц шийдлийг Чикаго хотынхон гаргажээ. Уг хот нь 1893 онд Дэлхийн үзэсгэлэнг анх зохион байгуулснаас хойш олон улсын чанартай арга хэмжээг амжилттай зохион байгуулсаар иржээ. Чикаго 2016 оны зуны олимпын эрхэд өрсөлдөөд бүтэлгүйтсэн байна. Үүнийхээ дараа олимпын зарим цогцолборыг барих шаардлагагүй. Засвар, үйлчилгээний зардлыг бууруулахын тулд материал хэмнэх санал гаргажээ. Гэхдээ энэ санаа ирээдүйд л биелэлээ олох байх.

Бразилийн Рио де Жанейро хот энэ зун хөлбөмбөгийн ДАШТ-ийг зохион байгуулна. Мөн хоёр жилийн дараа буюу 2016 онд зуны олимп болон паралимпын тоглолтыг зохион байгуулах гэж байна. Өөрөөр хэлбэл, нэг сумаар хоёр туулай хэрхэн буудахыг бодит жишээгээр үзүүлж буй хэрэг юм. Олимпын цэнгэлдэх хүрээлэнг байгуулахад тус улс 14 тэрбум ам.долларын зардал гаргаж байгаа аж. Энэ нь анх төлөвлөж байсан зардлаасаа хэтрээгүй.

Цаашид олимпын эрхийн төлөө хотууд хоорондоо өрсөлдсөн хэвээр байх нь тодорхой. Гэхдээ энэ нь ч тэдгээр хотын эдийн засагт хэрхэн нөлөөлөх нь тодорхойгүй аж. ■

Эх сурвалж: www.nbcnews.com

ҮНЭ ХАНШ

Хүнсний гол нэрийн бараа бүтээгдэхүүний үнэ ханшийг манай сэтгүүл уншигчдадаа тогтмол мэдээлж байгаа билээ. Сар шинийн баяр дэхсэн энэ өдрүүдэд мах, гурилын үнэ 14 хоногийн өмнөхөөс кг тутамдаа 500-1000 төгрөгөөр өсчээ.

/Нэгдүгээр сарын 25-ны байдлаар/

Мах /кг.төгрөг/

| Төрөл | Захуудын нэр/үнэ | | |
|-----------|------------------|------------|------------|
| | "Хүчит шонхор" | "Бөмбөгөр" | "Миркури" |
| Үхэр цул | 8200-8500 | 8500-9000 | 9000-11000 |
| Ястай | 7800-8200 | 8000-8500 | 9000-10000 |
| Хонь цул | 7000-7500 | 7500-8000 | 7500-8500 |
| ястай | 6500-7000 | 6800-7500 | 7000-8000 |
| Ямаа цул | 6000-6500 | 6300-6800 | 6500-7200 |
| Ястай | 5500-6000 | 5700-6000 | 6000-6500 |
| Тахиа мөч | 5000-5500 | 5200-5500 | 6000-6500 |
| гуя | 4800-5500 | 5000-5500 | 5500-6000 |
| Адуу цул | 4800-5500 | 5000-6000 | 5500-6500 |
| ястай | 4200-5000 | 4700-5500 | 5000-6000 |

Хүнсний ногоо /кг.төгрөг/

| Төрөл | Захуудын нэр/үнэ | | |
|----------------|------------------|------------|-----------|
| | "Хүчит шонхор" | "Бөмбөгөр" | "Миркури" |
| Монгол төмс | 600-800 | 650-800 | 700-900 |
| Монгол лууван | 1000-1200 | 1000-1100 | 1200-1500 |
| Монгол сонгино | 1300-1500 | 1500 | 1500 |
| Монгол манжин | 1100-1300 | 1200-1500 | 1300-1800 |
| Монгол байцаа | 1200-1500 | 1200 | 1500-1800 |
| Сармис | 3500-4000 | 3000-4500 | 4000 |
| Цагаан лууван | 2000-2500 | 2500-3000 | 2500-3000 |

Гурил /кг.төгрөг/

| Төрөл | Хэмжээ | Захуудын нэр/үнэ | | | | | |
|-------------|--------|------------------|-------|------------|-------|-----------|-------|
| | | "Хүчит шонхор" | | "Бөмбөгөр" | | "Миркури" | |
| | | 10 кг | 25 кг | 10 кг | 25 кг | 10 кг | 25 кг |
| Улаанбаатар | дээд | 12500 | 20500 | 13000 | 20000 | 14000 | 23000 |
| Алтантариа | дээд | 11500 | 25000 | 12000 | 24500 | 12500 | 26500 |
| | I | 8500 | 18500 | 9000 | 19000 | 9500 | 21000 |
| | II | 5000 | 9500 | 5500 | 10000 | 6000 | 11000 |
| "Атар" | дээд | 11500 | 26000 | 11500 | 25500 | 12500 | 26500 |
| | I | 8000 | 18500 | 8000 | 18000 | 9000 | 19000 |

Бусад бараа бүтээгдэхүүний үнэ

| Төрөл | Захуудын нэр/үнэ | | |
|-----------------|------------------|------------|-----------|
| | "Хүчит шонхор" | "Бөмбөгөр" | "Миркури" |
| Ургамлын тос | 3000-3500 | 3200-3500 | 3500-4000 |
| Элсэн чихэр | 1600-2000 | 1800-2000 | 2000-2500 |
| Цагаан будаа | 1800-2000 | 2000-2200 | 2000-2500 |
| Гурвалжин будаа | 1800-200 | 2000-2200 | 2200-2500 |
| Давс | 600-1000 | 500-800 | 500-1000 |

ХОТ

ЭДИЙН ЗАСАГ ДАХЬ ТӨРИЙН ОРОЛЦООГ БАГАСГАНА

Б.АЛТАЙ

Улаанбаатар банкныг хувьчлах тухай “зар” гарсан. Төлөвлөгөө ёсоор энэ онд тус банкныг хувьчилна. Ийм эрх нь Төрийн өмчийн хороо, Засгийн газарт бус нийслэлд байгаа. Өөрөөр хэлбэл, Улаанбаатар хотын банк орших, эс орших эсэхийг НИТХ-ийн төлөөлөгчид шийднэ гэсэн үг. 50 тэрбум төгрөгийн өөрийн хөрөнгөтэй банкныг гурван тэрбумаар хувьчилна гэжээ. Энэ нь гурван тэрбум төгрөгөөр

шууд хувьчилна гэсэн үг бас биш юм. Урьдчилсан байдлаар тогтоосон үнийн санал. Ийм мэдээлэл түгэн байгаа энэ цагт хотоос дараах бодлогыг гаргаж, амжлаа.

НИТХ-ын XIV ээлжит хуралдаанаар нийслэлийн өмчийн талаар баримтлах бодлогын тухай хэлэлцсэн юм. Ингэснээр Улаанбаатар хот анх удаа өмчийн талаар баримтлах бодлогоо тодорхойлов. Монгол Улсын хэмжээнд төрийн өмчийн эд хөрөнгийг хувьчлах үзэл баримтлал, хувьчлах хөтөлбөр

чиглэлийг батлан мөрдөж байсан. Гэвч төрийн өмчөөс орон нутагт өмч шилжүүлснээс хойш нийслэлийн өмчийн талаар баримтлах бодлогын бичиг батлагдаагүй өнөөг хүрчээ. Тиймээс нийслэлийн өмчийн талаар баримтлах бодлогын баримт бичгийг боловсруулан хэлэлцүүлж байгааг Нийслэлийн Засаг даргын Санхүү эдийн засгийн асуудал хариуцсан орлогч Н.Батаа онцолсон нь бий.

Дээрх бодлогыг хэрэгжүүлснээр өмчийн үр ашиг, өгөөж, эдийн засгийн чадавхи дээшлэх юм. Мөн тогтвортой хөгжлийг хангаж, нийслэлийн өмчийг үнэ цэнэтэй, үнэлж болохуйц, өрсөлдөх чадвартай болгох аж. Үүнийг нийслэлийн өмчийн харилцааны менежментийн оновчтой бодлого хэмээн нэрлээд байгаа.

Бодлого гарч, хэрэгжих болсноор өмчийн талаар баримтлах зарчимд багагүй ахиц дэвшил гарч байгаа юм. Тухайлбал, нийслэлийн өмч, газрын харилцаа нь илүү оновчтой, ил тод хариуцлагатай хандлага руу шат ахиж байна. Энэ чиглэлийн шийдвэр нь судалгаа, шинжилгээнд суурилсан. Оролцогч талуудын хууль ёсны эрх ашгийг харилцан хүндэтгэсэн. Мөн урт хугацаанд тогтвортой байхаар бодлогын баримт бичигт суулгажээ. Түүнчлэн компанийн сайн засаглалын зарчмыг нэвтрүүлж, эдийн засаг дахь төрийн эзэмшлийн хувь хэмжээг багасгах тал руу бодлого нь хэрэгжих юм байна. Цаашилбал мэргэжлийн холбоод болон хувийн хэвшлийн үүрэг, оролцоог нэмэгдүүлэх. Төр, хувийн хэвшлийн түншлэлийн үр дүнтэй арга хэлбэрийг нэвтрүүлэхээр болжээ.

Орон нутгийн өмчит үйлдвэрийн газрууд алдагдалтай ажилладаг. Гэтэл яг адилхан ажил үйлчилгээ»

ҮНЭ ЦЭНЭТЭЙ ХӨРӨНГӨ

Нийслэлийн үл хөдлөх хөрөнгийг нэг бүрчлэн тоолж, татвар төлөгч иргэний мэдээллийн нэгдсэн сантай боллоо. Ингэснээр далд эдийн засагтай болжээ. Мөн татварын ногдуулалт, төлөлтийг сайжруулах. Орон нутгийн төсвийн орлогын тогтвортой эх үүсвэрийг нэмэгдүүлэх зэрэг ач холбогдолтой аж.

Энэхүү ажлын үр дүнд нийслэлийн төсөвт 2.4 тэрбум төгрөгийг төвлөрүүлж, шинээр 1644 ажлын байр “илрүүлжээ”. Мөн 2900 татвар төлөгч иргэнийг шинээр бүртгэсэн байна. Үл хөдлөх хөрөнгийн тооллогоор нийслэлд 2.8 их наяд төгрөгөөр үнэлэгдэх хөрөнгө байгаа аж.

Гэхдээ үнэлгээ нь бодит үнэлгээ болж чадахгүй гэж Нийслэлийн удирдлагын зөвлөлөөс үзсэн байна. Учир нь иргэд татвар бага төлөхийн тулд өөрсдийн үл хөдлөх хөрөнгөө бодит үнэлгээнээс доогуур үнэлдэг. Эсвэл банкны зээлд хамрагдахын тулд хэт өндөр үнэлэх явдал цөөнгүй байдаг гэнэ.

Үнэ цэнэтэй үл хөдлөх хөрөнгө нийслэлийн эдийн засгийн чадамжийг харуулах нэг үзүүлэлт. Иймээс үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний тогтолцоог сайжруулах шаардлага байгааг удирдлагын зөвлөлийн гишүүд хэлсэн юм. Мөн үл хөдлөх хөрөнгийн үнэлгээний тогтолцоог боловсронгуй болгосон журам боловсруулах аж.

явуулдаг хувийн хэвшлийнхэн ашигтай ажиллаж болоод байгааг НИТХ-ын зарим төлөөлөгчид хэлж байсан. Иймээс энэхүү бодлогын баримт бичигт хариуцлагыг чангатгах, алдагдлыг хэрхэн барагдуулах зэрэг зохицуулалтыг шигтгэж өгөх нь зүйтэйг хэлж байсан юм.

Хотын захирагч Э.Бат-Үүл “Төрийн өмчийн үйлдвэр үйлчилгээний газруудын үйл ажиллагааг орчин үеийн техник, технологи дээр тулгуурласан чадварлаг менежментийг нэвтрүүлж, чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээг үзүүлдэг болгохоор энэ баримт бичигт тусгаж байгаа. Ер нь ганцхан орон нутгийн өмчит үйлдвэрийн газар биш нийслэлийн хүн амыг хамарсан, нийгмийн ач холбогдол бүхий ашгийн бус үйлдвэрийн газруудыг төсөвт байгууллага болгон өөрчлөн байгуулах. Мөн алдагдлыг нийслэлийн төсвөөс санхүүжүүлэх. Үнийг чөлөөлөх хувилбаруудын аль боломжтойг хэрэгжүүлж болохоор тусгасан” хэмээн



тэмдэглэсэн.

Нийслэлийн өмчийн талаар баримтлах бодлогын баримт бичиг нь нийслэлийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн талаар, нийслэлийн өмчийг түрээсийн гэрээгээр эзэмшүүлэх хувьчлах үйл явц болон газрын харилцааны чиглэлээр баримтлах бодлого хэмээн тодорхойлж байгаа юм. Нийслэл өмчөө хариуцах эзэнтэй болгох, хамгаалах, арчлах, өмчөө баталгаажуулан хөрөнгө

босгоход дээрх бодлогын баримт бичиг чухал аж.

Мөн хөрөнгө оруулалтын нэгдсэн бодлогын хүрээнд өнөөгийн болон ирээдүйн үнэ цэнэ өндөр байхуйц үйл ажиллагаанд хөрөнгө оруулалт хийх. Ингэснээр нийслэлийн хөрөнгийг өсгөнө, газар болон түүхий дээрх үл хөдлөх хөрөнгийн үнэлгээг тогтоож, үр ашигтай эдийн засгийн эргэлтэд оруулан, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх аж. ■

ҮЗЭЛ БОДОЛ

УУЛ УУРХАЙ ХИЙГЭЭД ХӨРӨНГИЙН ТӨЛӨӨХ ГЛОБАЛ ӨРСӨЛДӨӨН



Ж.ГӨЛГӨӨ (ДОКТОР)

Монголын дотоодын нийт бүтээгдэхүүний 30 гаруй хувь нь уул уурхайн салбарт бий болж байгаа. Ер нь нөхөн үйлдвэрлэлийн эл хэв загвар нэг хэсэгтээ хадгалагдах болно. Эрдсийн олборлолт давамгайлсан загвараас бид ойрын ирээдүйд татгалзаж чадахгүй. Яагаад гэвэл тус салбар манай эдийн засгийн өсөлтийн үндсэн хүчин зүйл, гол хурдасгуур хэвээр байх болно.

Уул уурхайн салбарыг цаашид хөгжүүлэхэд шийдвэрлэх хүчин зүйлийн нэгд хуримтлалын асуудал жагсах нь мэдээж. Их хэмжээний анхны хөрөнгө шаарддаг, бас тэр хөрөнгөө эргүүлж нөхөхөд бусад үйлдвэрлэлээс илүү хугацаа шаарддаг нь энэ салбарын онцлог. Томоохон

ордуудын хувьд эрэл хайгуулын ажлаас олборлолт эхлэх хүртэлх “бойжилтын” хугацааг 10 орчим жил гэж дэлхий нийтээр хүлээн зөвшөөрсөн. Ашгаа нөхөх хүртэл дахиад түүнээс багагүй хугацаа хэрэгтэй. Үндэсний компаниудын хуримтлалын боломж хязгаарлагдмал байгаа өнөөгийн шатанд бид уул уурхайдаа гадаадын хөрөнгө оруулахаас өөр аргагүй.

Өнөөдрийн даяарчлагдсан ертөнцөд хөрөнгийн төлөө өрсөлдөөн глобал шинжийг нэгэнт олчихоод буй. Үндэстэн дамнасан корпорациудын хувьд алт олборлохын тулд хөрөнгөө Намибид оруулах уу, эсхүл Австралид уу, Мексикэд үү, Монголд уу гэдэг нь газар зүйн байршил гэхээсээ илүү, үр ашгийн шалгуураар шийдэгдэх болсон. ▶

► Иймээс эрдсийн баялагтай орон нь зөвхөн Монгол биш гэдгээ бид байнга санах ёстой.

Эрдсийн салбар дахь бизнесийн хоёр дахь онцлог ихээхэн эрсдэлтэй салбар юм. Хайгуулын ажил азгүйтэх, үнийн мөчлөгт өртөх, шинэ өрсөлдөгч гэнэт бий болох зэрэг байгаль, бас зах зээлийн эрсдэлүүд түүнийг байнга дагалдаж байдаг. Монголын нөхцөлд эдгээр материаллаг эрсдэл гэхээсээ илүү субъектив эрсдэл эл салбарт илүү бэрхшээл учруулсаар буй. Энэ нь юуны өмнө, хуулийн орчин тогтворгүй, иргэний нийгмийнхэн хийгээд орон нутгийнхан энэ салбарын нэгдмэл бодлогод захирагддаггүй дур зоргоороо авирладагт оршино. Эдгээрийн жишээг холоос эрэх хэрэггүй. 2012 оны сонгуулийн өмнө санд мэнд гаргасан стратегийн салбар дахь гадаадын хөрөнгийн оролцооны тухай хуулиа бид жил гаруйн дараа Хөрөнгө оруулалтын тухай хуулиар хүчингүй болгов. Урт нэртэй хуулийн хэрэгжүүлэх ажлыг одоо хэр нэг мөр болгож чадаагүй хэвээр л байна. Одоо Ашигт малтмалын хуулинд өөрчлөлт орох нь гэсэн хүлээлт үүсээд буй.

Гурав дахь чухал хүчин зүйл нь эрдсийн болон капиталын нөөц өмчлөгчдийн хооронд ашгийг хэрхэн хуваах вэ гэдэг юм. Энэ шалгуурын үндсийг ашигт малтмал ашигласны төлбөр буюу роялтийн түвшин бүрдүүлдэг. Эдийн засгийн агуулгаараа роялти нь төр өмчөө хэрэгжүүлж буй хэлбэр юм. Нөхөн төлждөггүй нөөц хорогдсоны төлөөх төлбөрийн агуулгыг ч давхар илэрхийлдэг. Оюутолгой зэрэг төсөлд эрдсийн нөөцийг Монголын талын хувь хөрөнгөд оруулж тооцох учиртай гэсэн үзэл баримтлал төөрөгдөл болох нь энд харагдаж байна. Өөрөөр хэлбэл, роялтийн жил жилийн төлбөр нь эрдсийн баялгийн өмчлөлийг ашигласан тэрхүү бодит хэмжээгээр нь хэрэгжүүлж буй хэрэг юм.

Иймээс энэ төлбөрийн хэмжээ тодорхой, тогтвортой байхаар хуулиар баталгаажуулсан байх нөхцөлд л хөрөнгөө оруулах нь аюулгүй гэх итгэл гадаадын компаниудад төрөх болно. Саяхны Хөрөнгө оруулалтын хуулиар эл төлбөрийг томоохон төслүүдийн хувьд тодорхой хугацаанд тогтвортой байхаар заасан нь чухал ач холбогдолтой болсон. Аргентин, Индонез, Чили, Перу, Гана зэрэг

орныг хамруулан хийсэн судалгаанаас үзэхэд эдүгээ уул уурхай дахь ашгийг хөрөнгө оруулагч, төр хоёр 52 болон 48 харьцаагаар хуваадаг аж. Нийтийн салбарын дээрх 52 хувийн орлого нь роялтийн зэрэгцээ ашгийн татвар, нэмэгдсэн өртгийн болон импортын татвар, экспортын татвар, ногдол ашгийн татвар, гадаадын ажиллагчдын цалингийн татвар, шатахууны татвараас бүрддэг байна. Монголын нөхцөлд ч роялти дээр газрын, байгаль орчны, лицензийн зэрэг төрөл бүрийн төлбөр хураамж, татваруудыг нэмбэл “дундаж ашигтай нийтлэг үйлдвэрлэл”-ийн 25-30 хувийн ашгийн татвартай тэнцэхүйц тоо гардаг. Үүний дээр уул уурхайн салбарын шууд бус өгөөжийг, тухайлбал ажлын нэмэгдэл байр, орон нутгийн нийлүүлэлт, дэд бүтцийн хөгжилд өгч буй дэм зэргийг бодолцох ёстой.

Австрали зэрэг нэлээд оронд борлуулалтын нийт орлогоос зардлыг хассан дүнгээс өөрөөр хэлбэл, ашгаас нь роялтийг тооцдог байна.

Чили улс 2010 онд роялтийн хэмжээг эрдсийн төрөл, уурхайн цар хүрээнээс хамааруулаад 4-9 хувь байхаар хуульчилсан. Өмнө нь 4-5 хувь байсан төлбөрийг ийнхүү өсгөхдөө 2018 он хүртэл шилжилтийн хугацааг тогтоож өгчээ. Өөрөөр хэлбэл роялтийг зах зээлийн түр хэлбэлзлэлд суурилан өөрчилж болдоггүйн жишээ энэ аж. Манай хуулиар ашигт малтмалын борлуулалтын биет хэмжээнд суурилан биржийн үнэлгээний дагуу тооцох аргачлалыг нь заасан. Нүүрс, төмрийн хүдэр зэрэг эрдэст БНХАУ-ын биржийн үнэ хэрэглэж буй үндэслэл муутай гэх гомдлыг үйлдвэрлэгчид гаргасаар байгаа. Австрали зэрэг нэлээд оронд борлуулалтын нийт орлогоос зардлыг хассан дүнгээс өөрөөр хэлбэл, ашгаас нь роялтийг тооцдог байна. Энэ нь эрдсийн үнийг хэлбэлзлийг илүү тусгадаг аргачлал аж. Иймээс роялтийг тооцох суурь үнийг илүү үндэслэлтэй, үйлдвэрлэгчдийг дэмжсэн болгох шаардлага байж мэднэ.

Өдгөө эрдсийн салбарт холбогдож буй дөрөв дэх сэдэв нь төрийн үүрэг оролцоо. Гадаадын шууд болон хэтэвчний хөрөнгө оруулалтын

давуу тал нь төр түүний төлөө аливаа эрсдэл хүлээдэггүй. Эргэн төлөх хариуцлагыг нь үүрдэггүйд оршино. Чухам энэ үүднээс гадаадын хөрөнгийг уул уурхайн салбарт хөхиүлэн дэмжих хэрэгцээ үүсдгийг тайлбарлах нь илүүц биз ээ. Эрдсийн түүхий эдийн олборлолт, ашиглалт, боловсруулалтад үндэсний оролцоо байвал түүнээс Монголд унах ашиг нь илүү байна. Мөн хяналт удирдлагыг үр дүнтэй тавьж чадна гэсэн ойлголт бидний сэтгэхүйд түгээмэл байгаа. Ийм үзэл баримтлал практик дээр тэр бүр нотлогдохгүй байгаа. Үүний тод жишээ нь Энержи ресоурс, Эрдэнэс-Таван толгой, “бага” Таван толгой уурхайнууд дахь дэндүү ялгаатай менежментийн түвшин, үр ашгийн үзүүлэлт. Ер нь төрийн зорилго бол аливаа ордод тэргүүн технологи ашиглуулах, зардал доогууртай ажиллуулах, энэ үндсэн дээр төсөвт оруулах татварыг аль болохоор нэмэгдүүлэх явдал гэвэл зохилтой. Хэчнээн олборлолт хийсэн, ямар үнээр борлуулсан, хэдий зардал гаргасан зэргийг орчин цагийн санхүүгийн аудит, лабораторийн шинжилгээ, гаалийн бүртгэлээр тогтоочихож болдог юм байна. Эл хяналтын төлөө заавал “дотор” нь орох гэж зүтгэх нь тийм ч оновчтой шийдэл биш бололтой. Оюутолгойн 34 хувийг эзэмших гэж зүтгэснээс бид хувь оролцооны төлбөрт унаж, ашиг хүртэх хугацаагаа хойш татсаар байгаа бус уу. Өөрөөр хэлбэл, уул уурхайн салбарт орох хөрөнгийн эдийн засгийн шалгуур нь ийм буюу. Харин хөрөнгө гадаадынх уу, дотоодынх уу, нийтийн өмчлөлийнх үү, хувийн хэвшлийнх үү гэдэг нь хоёрдох эрэмбийнх гэж болно.

Монголын уул уурхайд хамаарах дараагийн сэдэв нь “үндсэрхэл”. Уул уурхайн бүтээгдхүүн, тэр дундаа түүхий болон хагас боловсруулсан эрдсийн бараа овор ихтэй хол тээвэрлэх нь эдийн засгийн хувьд боломжгүй. Иймээс өмнөд хөрш рүү л гаргахаас өөр сонголт бараг байхгүй, хойд хөрш маань бидний адил түүхий эд экспорт давамгайлсан орон. Дэлхийн хүн амын тавны нэг нь суудаг, дэлхийн хоёр дахь том эдийн засаг болох БНХАУ-тай хаяа нийлдэг маань манай уул уурхайн салбарын хувьд харин ч давуу тал болно. “Мөнгөний гарлыг үнэрээр нь таньж болдоггүй” гэдэг үг бий, мөнгөө л олж байвал хэнд худалдах нь чухал биш. Энд үндсэрхэл хэрэггүй. ■

БОДЛОГО ШИЙДВЭР

ЖИШИГ ҮНЭЭС ЭРДЭС БАЯЛГИЙН БИРЖ РҮҮ



Б.ТОГТОХ

Төрөөс эрдэс баялгийн салбарт баримтлах бодлогын баримт бичиг хүчин төгөлдөр боллоо. Он дамжин хэлэлцсэн эл бодлогын баримт бичиг бүхэлдээ манай улсын уул уурхайн ирээдүйг тодорхойлж байгаа юм. Алдаа байгааг үгүйсгэх аргагүй. Гэхдээ л чиглэл гарсан нь сайн хэрэг хэмээн салбарынхан онцолж байна. Бодлогогүйн улмаас гацаад байсан эрхзүйн шинэчлэл хөдөллөө. Эрдэс баялгийн салбар дахь эрх зүйн орчны шинэчлэл ирэх өдрүүдэд үргэлжилнэ. Зөвхөн энэ өдрүүдэд бус энэ хаврын УИХ-ын чуулганы “топ” сэдэв байх нь дамжиггүй. Үүнд,

- Газрын тосны тухай хууль,
- Газрын хэвлийн тухай хууль,
- Олборлох үйлдвэрлэлийн ил тод байдлын тухай хууль,
- Ашигт малтмалын тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, өргөн барих,

хэлэлцэх, батлах асуудал багтаж буй. Мөн Засгийн газраас батлах уул уурхайн томоохон хөтөлбөрүүд ч энд хамаарагдах юм. Тухайлбал, “Монгол зэс”, “Монгол төмөр”, “Монгол жонш” хэмээх эрдэс түүхий эдэд түшиглэсэн хөтөлбөр хэр амжилттай хэрэгжихээс цөөнгүй зүйл шалтгаална.

Хүний өдөрт тутмын хэрэглээ газрын хэвлийгээс авч байна. Тухайлбал, ухдаг, ургуулдаг зүйлсийг бид идэж ууж хэрэглэсээр. Ургадаггүй болгоныг ухаж авч хэрэглэхээс өөр аргагүй. Иймд уул уурхайн бүтээгдэхүүнгүйгээр хүн төрөлхтөн оршин тогтнох боломжгүй. Дээрх бодлогыг тодотгосон. Цаашдаа уул уурхайн салбар улс орны эдийн засагт ямар үүрэг гүйцэтгэх. Мөн бид уул уурхайгаа хэрхэн үр бүтээлтэй ашиглах учиртайг сануулсан “Эрдэс баялаг-2025” хэлэлцүүлэг шинэ оны эхээр болсон билээ.

Уул уурхайн яамнаас зохион байгуулсан бодлогын хэлэлцүүлгээс

ирэх арван жилийн салбарын баримжаа тодорсон. Өөрөөр хэлбэл, Монгол Улс 2025 он хүртэл эргэлт буцалтгүйгээр уул уурхайн салбартаа түшиглэн хөгжих юм байна гэсэн ойлголтыг тэнд оролцсон 300 гаруй төлөөлөгч өвөртлөөд буцсан.

Уул уурхайн яамнаас 2016 он гэхэд эрдэс баялгийн бүтээгдэхүүний экспортыг хоёр дахин нэмэгдүүлэх зорилт тавьсан. Нөгөөтэйгүүр ашигт малтмалын үнэ унаж, гаднын хөрөнгө оруулалт 30 хүртэлх хувиар багассан. Ийм үед төсвийн орлогын 20 гаруй хувийг уул уурхайгаас бүрдүүлэх гэж байгаа нь жирийн бус мэт. Нөхцөл байдал сайнгүй байгаа цагаар дээрх хэлэлцүүлэг болсноор ихээхэн анхаарал татаж байв.

Уул уурхайн салбар ДНБ-ий 17, нийт экспортын 81, гадаадын шууд хөрөнгө оруулалтын 73 хувийг тус тус эзэлж буй. Энэ бол сүүлийн гурван жилийн тоон үзүүлэлтээс бүрдсэн дүгнэлт. Нэг талаасаа уул уурхайгүйгээр бид хөгжиж чадахгүй нь гэсэн утга бүхий хариултыг дээрх тооноос харж болно. Энэ онд геологийн судалгааны ажилд 10 тэрбум төгрөг зарцуулахаар төсөвт суулгасан. Ирэх жилүүдэд уг мөнгөний хэмжээ хамгийн багадаа хоёр дахин өсөх. Цаашилбал гурав дахин нэмэгдэх салбарын яамны төсөөлөл бий.

Хэрэв геологийн салбарт зарцуулах хөрөнгө оруулалт жил тутам нэмэгдэх аваас уул уурхайн үйлдвэрлэл хүрээгээ тэлнэ гэсэн үг. Энэ хэрээр уул уурхайн салбараас хүртэх орлогын хэмжээ үлэмж тэлэх нь гарцаагүй. Дээр дурдсан 10 тэрбум төгрөгийн 75 хувийг геологийн зураглал, ерөнхий эрлийн ажилд зарцуулах аж. Дэлхийд жилд зургаан тэрбум ам.долларын хөрөнгө оруулалтыг хайгуулд зарцуулдаг. Үүний 10 хувийг Монгол ▶

► Улс руу татахын төлөө бодлогын яамнаас анхаарна гэлээ.

Өнгөрсөн оны байдлаар улсын хэмжээнд нийт 3055 тусгай зөвшөөрөл байгаа юм. Үүнээс ашиглалтын тусгай зөвшөөрөл 1292. Хайгуулынх 1763. Та мартаагүй байх. 2005 онд хүчин төгөлдөр тусгай зөвшөөрлийн тоо нийт газар нутгийн 69.6 хувийг эзэлж байсан. Тэгвэл 2013 оны арванхоёрдугаар сарын байдлаар тусгай зөвшөөрөл 9.7 хувь болж, эрс буурсан байна.

Манай улсын хувьд нөөцийн ихэнх хувь нь Төвийн болон Зүүн бүсэд төвлөрч байгаа аж. Нийтдээ улсын хэмжээнд 1170 гаруй орд байгаагаас стратегийн ач холбогдол бүхий 15 орд. Мөн стратегийн ач холбогдолтой байж болох 39 орд байгаа юм. Уул уурхайн сайд Д.Ганхуяг “Ашиглалтын тусгай зөвшөөрөл сүүлийн жилүүдэд өсөж байгаа нь бодит хөрөнгө оруулалт нэмэгдэж байгааг харуулж байна” хэмээсэн.

Уул уурхайн салбарт бизнес эрхэлж буй эздийн дургүйг хүргэдэг нэг зүйл бий. Тэр нь уул уурхайн бүтээгдэхүүний жишиг үнэ тогтоох асуудал. Нүүрс, жоншны компаниудад илүү халгаатай гэх жишиг үнэ удахгүй шинэчлэгдэх бололтой. Үүнийг зохицуулах боломжит хувилбар нь Эрдэс баялгийн бирж байгуулах хэмээн Монголын экспортлогчдын холбооны ерөнхийлөгч Д.Галсандорж хэлсэн юм.

“Эрдэс баялаг-2025” хэлэлцүүлгийн үеэр оролцогчдын хөндөөд байсан биржийн асуудлаар Уул уурхайн яамнаас ажлын хэсэг байгуулжээ. Эрдэс баялгийн бирж байгуулах замаар эрдэс түүхий эдэд биржийн зарчмаар эндээ үнэ тогтоох юм. Үүнээс гадна баялгийн нөөцийг нэмэгдүүлэх зорилгоор Үндэсний геологийн алба байгуулах саналыг Уул уурхайн сайд дэвшүүлсэн.

Дэлхийн банкны судалгаагаар уул уурхайн бүтээгдэхүүний хэрэгцээ 2030 он хүртэлх онуудад 2.4 хувийн өсөлттэй байх юм. Энэ хугацаанд дэлхийн хүн ам жилд дунджаар 0.8 хувиар өсөх аж.

Дунд болон урт хугацаанд уул уурхай, газрын тосны салбар эдийн засгийн тогтвортой, хөгжлийн түүчээ болж, эрх зүйн орчин тогтвортой, илүү ойлгомжтой байх нь гэдгийг танд хэлье. Үүнийг өрсөлдөх чадвар бүхий алсын хараатай бодлого хэмээн “Эрдэс баялаг-2025” нээлттэй хэлэлцүүлэг

тодорхойлсон юм.

Уул уурхайн яамны дэд сайд О.Эрдэнэбулган “Ирэх арван жилд уул уурхайн бүтээгдэхүүний боловсруулалтын түвшинг нэмэгдүүлж, нэмүү өртөг шингээсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэх. Ингэснээр олон улсын зах зээл өрсөлдөх чадвараа дээшлүүлэн ажиллах боломжтой. Тиймээс ойрын хугацаанд олборлогчоос үйлдвэрлэгч орон болно. Үүний төлөө салбарын бодлого чиглэж байна” гэв.

Хэлэлцүүлгээс уриалга гаргасан юм. Эрдэс баялгийн салбарт үйл ажиллагаа явуулж буй аж ахуйн нэгжүүдэд шинэ, дэвшилтэт техник,

технологи нэвтрүүлэх. Ингэснээр байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх асуудалд онцгой анхаарч ажиллах учиртайг дээрх уриалгад онцолжээ. Мөн үйлдвэрлэн гаргаж буй бүтээгдэхүүний чанар, стандартыг сайжруулан олон улсын зах зээлд өрсөлдөхүйц хэмжээнд хүргэх талаар анхаарч хариуцлагатай, ил тод ажиллахыг уриалсан. Цаашдаа үйлдвэрлэлийн бүтээмжийг ахиулж, өртөг зардлыг бууруулан, боловсруулалтын түвшинг дээшлүүлж нэмүү өртөг шингээх чиглэл баримтлах нь оновчтой сануулсан. Зах зээл ч үүнийг тулгаж буй. ■


СОД ХҮН

ХХІ ЗУУНЫГ БҮТЭЭСЭН НЬ

Б.БЯМБАДОРЖ

Бид өдөр бүр Альберт Эйнштэйний бүтээлтэй харьцаж, хэрэглэдэг. Машин доторх GPS систем нь хэрэглэгчийн зорьсон газарт нь аюулгүй хүрэхэд нь тусалдаг. Дэлгүүрт худалдан авсан барааг автомат уншигчаар тооцож бүртгэдэг. Мөн бид сүүлийн удаа аялалд явахдаа гэр бүлийнхээ зургийг дижитал аппаратаар дарсан.

Альберт Эйнштэйний хамгийн нэр алдартай судалгааны, онолын ажлуудаас энгийн нүдээр уншихад бидний амьдралд бодитой хэрэг болох зүйл олж харахгүй байх. Харин түүн дээр үндэслэж бусад эрдэмтэд бидний амьдралыг хөнгөвчилж чадсан технологиуд байна. Тухайлбал компьютер, зурагт, CD тоглуулагч зэрэг нь Альберт Эйнштэйний онолууд дээр суурилсан билээ.



Альберт Эйнштэйний. 1921 он

Тэрбээр 1879 онд Германы нэгэн еврей гэр бүлд мэндэлжээ. Гэхдээ гэр бүлийнхэн нь еврей үндэстний шашин шүтлэгийг дагадаггүй хүмүүс байв.

Альберт бага ангидаа хичээлдээ онцгой сайн сурдаггүй байж. Харин танилуудаасаа түр авсан эвклидийн ►



Нью-Йорк хот. Альберт Эйнштэйнийг угтсан баярын жагсаал. 1921 он

► математик, физик, логик тооцооллын тухай номнууд уншиж бие даан суралцаж байжээ. Альбертийг хүүхэд байхад эцгийнх нь халаасны луужин түүнийг их гайхшруулж байв. Луужингийн зүүг ямар нэг үл үзэгдэх хүч хөдөлгөж байгаа нь Альбертийг гайхшруулж байлаа.

Альберт цэрэг таталтаас зайлсхийхийн тулд эцэг Херман Эйнштэйнгээсээ зөвшөөрөл авч, 1896 онд Германы эзэнт гүрний иргэншлээс татгалзав. Үүний дараа Эйнштэйний гэр бүл Швейцарь улсыг зорьжээ. Альберт тус улсад ирээд Цюрих хотын Политехникийн Дээд сургуульд элсэхээр шалгалт өгөв. Ерөнхий шалгалтууд дээр хангалттай үнэлгээ авч, математик, физик хоёрынх дээр дээд оноог нь авчээ. Тиймээс уг сургууль 17 настай Альбертийг элсүүлж авсан юм.

Энэ үед буюу 1880 –аад оны сүүлчээр “цахилгаан гүйдлийн дайн” АНУ –д оргил үедээ хүрч байв. Нэг талаас Томас Эдисоны цахилгаан дамжуулах тогтмол гүйдлийг (DC) дэмжсэн эрдэмтэд, нөгөө талаас Никола Тесла зэрэг хувьсах гүйдлийг (AC) дэмжсэн эрдэмтэд хоорондоо өрсөлдөж байлаа. Удалгүй цахилгаан дамжуулалахад хувьсах гүйдлийг ашиглах нь илүү үр ашигтай гэдэг нь тодорхой болсон юм.

Альбертийн эцэг Херман Эйнштэйнд DC системд зориулж тоног төхөөрөмж нийлүүлдэг компанитай байв. Харин DC хоцрогдож, оронд нь AC дэлхий даяар орлож эхлэхэд Херманы компани ашиггүй болж дампуурав. Үүний дараа Альберт сургуулиа төгсөхөөр Швейцарьт үлдэж харин гэр бүл нь бизнесийн эрэлд гарч Итали улсыг зорьсон юм.

Цюрихт Политехникийн сургуулийг багшлах эрхтэй төгсөв. Альберт багшлах гэж хоёр жил ажил хайжээ.

Удалгүй аавынх нь танил Альбертийг Берн хотын оюуны өмчийн газар ажилд оруулж өгсөн нь ирээдүйн онолын физикчид үнэтэй туршлага олгосон юм. Ажлынхаа хүрээнд өдөр тутам физик, механикийн олон төрлийн ололт, нээлтүүдийн загварыг хянаж оюуны өмчийн эрхийг олгодог байжээ.

Гайхамшигт жил

Энд ажиллах хугацаандаа Альберт физикийн хувьд өөрийн гэсэн хэд хэдэн онол дээр ажиллаж байж. Үүний дүнд “Эйнштэйний гайхамшигт жил” гэгдэх 1905 онд дэлхийн физикийн салбарт томоохон өөрчлөлт хийсэн дөрвөн онолыг тэр дэвшүүлжээ.

Үүнд фото-электроны эффектийг амжилттай тайлбарласан. Энэ ажлаараа 1921 онд Нобелийн

шагнал хүртжээ. Хожим нь энэ онол дээр суурилан зурагт, дэлгэцийн технологиуд өндөр нарийвчлалтай дүрс гаргах чадвартай болсон юм.

Мөн тэрбээр Роберт Брауны 1827 онд микроскопоор ажигласан тоосонцор яагаад олон тийш, ямар нэг шалтгаангүй хөдөлж (Brownian Motion) байсныг нарийвчлан тайлбарлав. Тийнхүү атом гэгч нь зөвхөн онолын хувьд биш харин бодитой байдгийг баталжээ.

Гуравдугаарт, харьцангуйн тусгай онолыг дэвшүүлсэн хэрэг байв. Энэ нь ямар ч хоёр зүйл цаг хугацааг өөрийн хөдөлж байгаа хурдаас хамаарч өөр өөрөөр мэдэрнэ гэж тайлбарласан онол юм. Альберт 1916 онд үүнийгээ дэлгэрүүлэн, Исаак Ньютоны таталцлын хүчтэй нэгтгэжээ. Энэхүү харьцангуйн ерөнхий онол нь хар нүх зэрэг бусад олон сонин хачин зүйлс сансар огторгуйд байдгийг зөгнөв. Түүнээс гадна цаг хугацаагаар “аялах” нь онолын хувьд боломжтой гэдгийг баталсан юм.

1905 оны түүний гайхамшиг нь дэлхийн хамгийн алдартай томъёо гэгдэх $E=mc^2$ байв. Энд ямар нэг зүйлийн энерги нь түүний жинг гэрлийн хурдыг квадратаар үржүүлсэнтэй тэнцүү гэж томъёолжээ. Энэ нь анхны атомын бөмбөгийн судалгаанд шууд бус нөлөө үзүүлсэн юм.

Ийнхүү Альберт физикийн ертөнцөд хийсэн өөрчлөлтөөрөө алдаршиж, нэртэй судлаач болов. Дараа нь 1909 онд оюуны өмчийн ажлаасаа гарч нэр хүндтэй их сургуулиудад лектороор ажиллаж, Германы Физикчдийн Нийгэмлэгийн тэргүүн боллоо.

Гэхдээ Альбертийн зарим онолууд үл итгэлцэлтэй их тулгарч байв. Жишээлбэл түүний фото-электроны эффектийн онол 1905 онд хэвлэгдсэн. Гэхдээ хожуу 1921 онд л Нобелийн шагналаа хүртсэн. Мөн харьцангуйн ерөнхий онол нь орон зай ба цаг хугацааны муруйлтаас таталцал үүсдэг бөгөөд үүнээс болж гэрэл “хугарна” гэж байж. 14 жилийн дараа буюу 1919 оны тавдугаар сарын 29 –нд нар хиртэлтийг Их Британийн судлаач ноён Артур Эддингтон өөрийн багийн хамт ажиглажээ. Түүгээр Альбертийн дээрх онолыг баталсан юм.

Энэ ажиглалтын дүн дэлхий даяар таржээ. Ингэж Альберт Эйнштэйнд нэг л шөнийн дотор зөвхөн физикчдийн дунд биш, дэлхийд алдартай эрдэмтэн ►

► болжээ. Тухайн үеийн Английн хамгийн нэр хүндтэй сонин The Times үүнийг “Ертөнцийн ойлголт өөрчлөгдлөө” нэртэйгээр нийтэлсэн юм.

Эйнштэйн гудамжаар алхаж явахад нь түүнийг зогсоогоод “нөгөө онолоо тайлбарлаач” гэх хүн олон таарах болов. Альберт онцгой ухаанаараа алдартай ч мөн даруу зангаараа олонд үнэлэгдсэн нэгэн билээ. Тэрбээр хүмүүсийн анхаарлаас залхсан бололтой “Уучлаарай, хүмүүс намайг Доктор Эйнштэйн гэж байнга андуурах юм” гэж хэлээд цааш явах үе ч байж.

АНУ ба Дэлхийн хоёрдугаар дайн

Альберт Эйнштэйн анх 1921 онд АНУ –ыг зорьж Нью Йорк хотод иржээ. Түүнийг тус хотын захирагч Жон Фрэнсис Хайлань албан ёсоор тосож авч, олон нийтийн парад зохион байгуулав. Альберт энд гурван долоо хоногийн турш илтгэл тавьжээ. (Columbia, Princeton зэрэг олон нэртэй их сургуульд) Мөн хэд хэдэн хүлээн авалтад бусад эрдэмтэнтэй хамт оролцов. Тэрбээр 1932 он гэхэд Нью-Жерси мужийн Princeton их сургуульд профессороор ажилладаг болж, АНУ –д тогтмол очдог байв.

Дэлхийн нэгдүгээр дайн дуусч Герман улс дайны бүх бурууг “үүрэн” эдийн засаг, нийгмийн байдал нь хурцдаж байлаа. Германы нацист нам хүчээ авч, Адольф Гитлер 1933 онд Германы удирдагч болов. Еврей хүмүүсийн эсрэг янз бүрийн гадуурхал, хүчирхийллээрээ алдартай тус нам Германыг удирдмагц Альберт Эйнштэйн АНУ –д тэр чигээрээ үлдэхээр шийдсэн юм. 1933 оны дөрөвдүгээр сард нацистууд Германд байсан түүний гэрийг нэгжиж, хийсэн бүтээлийг нь шатаасан гэж Альберт дуулав. Мөн еврейчүүдийг албан ёсны ажлын байр эрхлэхийг хориглосон хууль баталсан байна.

Засгийн газрын хавчилгаас зугатаж маш олон еврей эрдэмтэн Германаас болон нөлөөнд нь байгаа орнуудаас АНУ –руу дүрвэж эхэлжээ. Тэдний дунд дэлхийн анхны цөмийн реакторыг бүтээгч Лео Силард, Энрико Ферми нар байв.

Дэлхийн хоёрдугаар дайн эхлэв. Лео Силард, Энрико Ферми хоёр өөрсдийн бүтээсэн технологиор асар хүчтэй тэсрэх бөмбөг хийж болно

гэдгийг мэдэж байснаар барахгүй Германчууд тийм зэвсэг хийхийг оролдож байгааг ч мэдэж байв. Иймд Лео Силард АНУ –ын Засгийн газарт захиа илгээсэн боловч түүний захиаг тоогоогүй байна.

Тухайн үед Альберт Эйнштэйн алдартай, олны танил байсан учир Силард нэрт онолын физикчийг зорилгоо. Түүний гарын үсэгтэй ямар ч захиаг Вашингтон хүлээж авна гэдэгт итгэлтэй байв. Тэрбээр Альбертийн гэрт очиж нөхцөл байдал хурцадсаныг хэлэв. Цөмийн бөмбөг хийх хамгийн тохиромжтой элемент плутонийг их хэмжээгээр германчууд худалдан авч байгааг ч дуулгав. Гитлер ийм аймшигт зэвсгийг хэрэглэхээс хоромхон зуур ч татгалзахгүй гэдгийг бас ойлгуулжээ.

Энх тайвныг эрхэмлэгч Альберт АНУ–ын ерөнхийлөгч Франклин Рузвельтэд бичсэн захидлыг нь уншаад, гарын үсэг зуржээ. Тэр нь Манхаттен төслийг эхлүүлжээ. Иймд АНУ дэлхийн хоёрдугаар дайнд цөмийн зэвсэг амжилттай хийж чадсан ганц орон нь болсон юм.

Энэ төсөл дээр Альбертийг ажиллуулахыг хориглосон нь түүний энхтайвныг эрхэмлэдэг үзэл байлаа. Өөрийнх нь ярилцлага, олон нийтийн лекц, илтгэлүүдээс үзэхэд түүнийг энхтайвны төлөө юу ч хийж магадгүй гэсэн сэтгэл төрүүлнэ. Иймд дэлхийн хамгийн аймшигтэй зэвсэг хийх ажлаас түүнийг чөлөөлсөн юм.

Хувийн үзэл бодол

Мэдээж физикчийн хувьд олон нийтэд алдартай байсан. Иймээс түүний бусад чиглэлийн хувийн үзэл баримтлал нь хүмүүст их чухал байв. Тухайн үеийн сонин хэвлэлүүд Альбертийн ертөнцийг үзэх үзэл, бурхан шашны тухай бодол, мөн нийгмийн зарим асуудал дахь санааг их сонирхдог байв.

Тэрбээр 1921 онд АНУ –д анх ирэхэд нь арьс өнгөөр ялгаварлан гадуурхалд “баригдсан” орон гэдгийг анзаарсан. Өнгөт арьстнууд зочид буудалд хонож болдоггүй, олон нийтийн газраар явах хориотой зэрэг олон хоригтой байв. Үүнийг Альберт ирмэгцээ эсэргүүцэж, АНУ –д амьдрах хугацаандаа түүнийг арилгахын төлөө их тэмцэж байсан нэгэн юм. Тэрбээр олон нийгмийн идэвхтнүүдтэй найзалж байв. Тэдний нэг нь Америкийн алдарт зохиолч өнгөт арьстан Лэнгстон Хьюз байжээ.

“Эйнштэйний арьс өнгөний ба яс үндэстний үзэл” ном 2005 онд хэвлэгджээ. Зохиолч Фред Жером Нью-Жерси муж дахь Албертийн хөршүүдээс нь ярилцлага авчээ. Нэгэн хөгшин эмэгтэй Эйнштэйнийг санаж байна уу гэхэд удаан алхаатай, арзгар, цагаан үстэй өвгөн гудамжаар нь явдаг байсан гэж ярилаа. Тэрбээр хөршийнхөө хүүхдүүдэд чихэр өгч, бүр нэг өнгөт арьстан хөршийн хүүхдийн их сургуулийн төлбөрийг төлж байсныг ч ярьж байв.

Альберт хэд хэдэн ярилцлагадаа дайн бол хүмүүсийн хамгийн аюултай “өвчин” гэж хэлж байсан. Энэхүү энх тайвны үзлээ ганц удаа үл тоосон нь атомын бөмбөгийн судалгааг эхлүүлэх захиан дээр гарын үсэг зурсан удаа байв. Тухайн үед Эйнштэйн Нацист Герман ийм зэвсэг гартаа авахаас эмээсэн гэж өөрөө хэлсэн юм. Харин дараа нь “Хэрэв би Германуудыг атомын бөмбөг хийж амжихгүй гэдгийг мэдсэн бол би юу ч хийхгүй байсан” гэж тэрбээр нас барахаасаа өмнө эмнэлэгт хэвтэж байхдаа хэлжээ.

Альберт Эйнштэйнийг 1955 оны дөрөвдүгээр сард эмнэлэгт унтаж байхдаа насан эцэслэжээ. Эмчлэгч эмч нь талийгаачийн тарихыг авчээ. Энэ нь хэзээ нэгэн цагт неврологи өндөр хөгжсөн үед тэр тархины чухам ямар хэсэг нь түүнийг тийм ухаантай болгосныг мэдэх зорилготой байв.

Хэдийгээр Эйнштэйн нас бараад хагас зуун жил өнгөрсөн ч түүний онолууд бидний амьдралд маш олон шууд ба шууд бус нөлөөтэй хэвээр. Жишээлбэл дижитал аппарат бүрт байдаг гэрлийг цахилгаан болгодог жижиг төхөөрөмж нь Эйнштэйний фото-электроны эффект дээр үндэслэсэн технологи юм. Мэдээж гэрлийг цахилгаан болгох энэхүү технологи нь нарны эрчим хүчний төхөөрөмжид ч мөн ашигладаг.

Хэзээ нэгэн цагт энэхүү нарны энергийг бидэнд “өгсөн” хүний тарихыг зөвхөн гаднаас нь биш дотор талаас нь нарийвчлан судалж дүгнэх чадвартай болох байх. Харин түүний онцгой ухаантай болсон бас нэгэн шалтгаан нь түүний зан чанар гэж өнөөхөндөө хэлж болохоор. Өөрийнх нь үгээр бол “Надад гоц ухаан байхгүй ээ. Би зүгээр их сониуч хүн” гэсэн нь түүний тархи онцгойдоо биш харин сониуч зан нь маш их боломж олгожээ гэж ойлгогдох юм. Ирээдүй бидэнд хэлээд өгнө. ■

ЭДИЙН ЗАСГИЙН ОНОЛД

ЭДИЙН ЗАСГИЙН СУБЪЕКТҮҮД БА ЗАХ



Ц.БАТХҮЯ
СЗЗДС-ийн Эдийн засгийн
тэнхимийн эрхлэгч

Өмнөх булангаар бид эдийн засгийн ухаан юуг судалдаг талаар авч үзсэн билээ. Энэ удаагийн буландаа эдийн засгийн харилцаанд оролцогч субъектүүд, тэдгээрийн хоорондын харилцаа ямар механизмаар дамжин хэрэгждэг талаар авч үзнэ.

Эдийн засаг нь бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх, хуваарилах, солилцох, хэрэглэхтэй холбоотой харилцаа гэдгийг бид мэднэ. Харилцаанд оролцогч хүмүүсийг тэдгээрийн ашиг сонирхол, харилцааг үүсгэгч хүчин зүйлс, арга, хэрэгсэл зэргээс хамааруулан дөрвөн үндсэн бүлэгт хуваадаг ба хүмүүсийн эдгээр бүлгүүдийг эдийн засгийн субъектүүд гэдэг. Үүнд:

- Өрх
- Пүүс
- Төр
- Гадаад сектор

гэсэн субъектүүд багтдаг.

Өрхийг хэрэглэгч, пүүсийг үйлдвэрлэгч, төрийг эдийн засгийн харилцааг зохицуулагч гэж авч үздэг ба тухайн улсын эдийн засгийн субъектүүд гадаад бусад орнуудын субъектүүдтэй харилцаанд ордог эдийн засгийг нээлттэй эдийн засаг гэдэг. Онолын хувьд анхлан судлаачдад цэгцтэй ойлголт өгөх зорилгоор улс орнуудыг хоорондоо эдийн засгийн харилцаанд ордоггүй гэж хийсвэрлэн, хялбаршуулсан загвар байгуулдаг ба энэхүү хийсвэр эдийн засгийн тогтолцоог хаалттай эдийн засаг хэмээдэг. Хүмүүс хаалттай эдийн засаг 21-р зуунд байхгүй гэж маргах талтай ч, дэлхийн эдийн засгийг нэг тогтолцоо гэж үзвэл хаалттай эдийн засаг болно. Нээлттэй эдийн засагт бусад улс орнуудын эдийн засгийн субъектүүдийг нийтэд нь гадаад сектор хэмээн үздэг.

Пүүс нь эдийн засгийн хүчин

зүйлсийг ашиглан бүтээгдэхүүн үйлдвэрлэж, нийгмийн хязгааргүй өсөн нэмэгдэж буй хэрэгцээг хангах замаар ашиг олдог, бие даан шийдвэр гаргах чадвартай эдийн засгийн субъект юм. Харин өрхүүд нь газар, хөдөлмөр, капитал, үйлдвэрлэл эрхлэх ур чадварыг эзэмшдэг, эдгээрийг зах зээлд нийлүүлж, пүүсүүдэд зарах замаар орлого олж, түүгээрээ пүүсээс бүтээгдэхүүн худалдан авч, ханамжаа хамгийн их байхаар хэрэгцээгээ хангадаг, бие даан шийдвэр гаргах чадвар бүхий эдийн засгийн харилцааны үндсэн субъектийн нэг юм.

Пүүс, өрх нь эдийн засгийн үндсэн суурь субъектүүд бөгөөд эдгээр нь захуудаар дамжин эдийн засгийн харилцаанд ордог. Бүтээгдэхүүн, үйлдвэрлэлийн хүчин зүйлс, санхүүгийн хэрэгслүүдийг худалдан авах болон худалдах үйл ажиллагаа явагдаж буй талбарыг зах гэдэг. Захыг ямар бүтээгдэхүүнийг арилжаалж, солилцож байгаагаар нь бүтээгдэхүүний, үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн, санхүүгийн гэх зэргээр ерөнхийлөн ангилдаг. Зөвхөн хэрэглээний бараа, үйлчилгээг борлуулж буй захыг бүтээгдэхүүний, газар, хөдөлмөр, капитал зэргийг солилцож буй захыг үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн зах гэх ба санхүүгийн хэрэгслийн худалдаалж буй захыг санхүүгийн зах гэнэ. Эдгээр нь ерөнхий ангилал бөгөөд тухайлсан бүтээгдэхүүн, хүчин зүйлээс нь хамааруулан барааны зах, үйлчилгээний зах, хөдөлмөрийн зах гэх мэтчилэн нарийвчлан ангилдаг. Энэ утгаар авч үзвэл дэлгүүр ч зах, ресторан, баар ч зах, сургууль ч зах, банк ч зах болно. Эдгээр нь юуг борлуулж байгаагаараа л ялгаатай боловч, эдийн засгийн харилцааны мөн чанарын хувьд нэгэн ижил билээ.

Ямар нэг хүнсний дэлгүүрт арилжаа явагдахад түүнд энэ бүтээгдэхүүнийг үйлдвэрлэсэн пүүс, түүнийг төлөөлсөн худалдааны төлөөлөгч буюу дэлгүүрийн эзэн, худалдагч, нөгөө талаас худалдан авах гэж буй өрхийн гишүүн хэрэглэгч гэсэн эдийн засгийн хоёр субъект харилцаанд оролцоно. Сургууль нь боловсролын үйлчилгээ үзүүлж буй зах бөгөөд түүнд боловсролын үйлчилгээг үзүүлж байгаа сургууль, түүний төлөөлөл болох багш, нөгөө талаас үйлчилгээ авч байгаа өрхийн гишүүн сурагч, тэдгээрийн эцэг, эх эдийн засгийн харилцаанд ордог.

Захуудад дор хаяж эдийн засгийн хоёр субъект өөр, өөрийн ашиг сонирхлын үүднээс харилцан ашиг тустай байдлаар оролцдог. Нэг субъект нь худалдан авагч, нөгөөх нь худалдагч тал болно. Худалдан авагч тал чанартай бүтээгдэхүүн, үйлчилгээ, үйлдвэрлэлийн хүчин зүйлсийг аль болох хямд авахыг эрмэлзэж байдаг бол худалдагч тал бүтээгдэхүүн, хүчин зүйлсээ аль болох үнэтэй борлуулж, их орлого, ашиг олохыг эрмэлзэж байдаг. Бүтээгдэхүүнийг өндөр үнэтэй зарж, илүү их ашиг олох гэсэн худалдагчийн сонирхлыг, хямд авах гэсэн худалдан авагч талын сонирхол, боломж нь хязгаарлаж байдаг. Ер нь энэ хоёр талт сонирхол л зах зээлийн гэх тэнцвэрийг үүсгэх үндсийн үндэс болдог билээ.

Бүтээгдэхүүний захад пүүс бараа, үйлчилгээг нийлүүлэх ба харин өрх түүнийг худалдан авагч байдлаар эдийн засгийн харилцаанд оролцдог бол үйлдвэрлэлийн хүчин зүйлсийн буюу нөөцийн зах дээр газар, хөдөлмөр, капитал, ур чадварыг өрх нийлүүлж, пүүс худалдан авдаг. Өөрөөр хэлбэл, бүтээгдэхүүний болон хүчин зүйлсийн захаар дамжин ►

www.mongolianeconomy.mn